

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР



**ОЮУНЫ ӨМЧИЙН БҮТЭЭЛИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН
ЭРГЭЛТЭД ОРЖ БУЙ ТАЛААРХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

(Албан хэрэгцээнд зориулав)

2021 оны 10 сар

Агуулга

НЭГ. УДИРТГАЛ.....	5
1.1 ТАНИЛЦУУЛГА	5
1.2 СУДАЛГААНД АШИГЛАСАН АРГА ЗҮЙ.....	7
1.3 СУДАЛГААНЫ АСУУЛГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ.....	7
1.4 СУДАЛГААНД ХАМРАГДАГСАД	9
ХОЁР. ПАТЕНТЫН МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭГДСЭН БҮТЭЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	16
2.1 МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЗАРИМ МЭДЭЭЛЭЛ	17
2.2 ШИНЭ БҮТЭЭЛ	20
2.3 АШИГТАЙ ЗАГВАР	22
2.4 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАР	24
2.5 ОЛОН УЛСЫН АНГИЛАЛ.....	27
ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....	29
3.1 ШИНЭ БҮТЭЭЛИЙН ПАТЕНТЫН ХУВЬД	29
3.2 АШИГТАЙ ЗАГВАРЫН БҮТЭЭЛИЙН ПАТЕНТЫН ХУВЬД.....	33
3.3 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ПАТЕНТЫН ХУВЬД	37
3.4 ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ	40
3.5 ОЮУНЫ ӨМЧИЙН БҮТЭЭЛИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ САНАЛ, ХҮСЭЛТ	41
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ	45
4.1 ДҮГНЭЛТ	45
4.2 САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	54
ТАВ. ХАВСРАЛТ.....	56
5.1 СУДАЛГААНЫ АСУУЛГА.....	56
5.2 СУДАЛГААНД ХАМРАГДАГСАД (<i>Мэдээллийн санд буй нэрээр бичсэн болно.</i>)	57
5.3 АЖЛЫН ХЭСЭГ, СУДАЛГААНЫ БАГИЙН ГИШҮҮД	59
5.4 ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	60
5.5 ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	61
5.6 ЗУРГИЙН ЖАГСААЛТ	62
5.7 АШИГЛАСАН НОМ, ЭХ СУРВАЛЖ	63

Монгол Улсын Үндсэн хуулийн Долдугаар зүйлийн 1-д “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна.” гэж, мөн зүйлийн 2-т “Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн.” гэж, Арван зургадугаар зүйлийн 8-д Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрх, эрх чөлөөг хуульчлахдаа “соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална” гэж тус тус заасан.

Оюуны өмчийн газар нь Үндсэн хууль болон Монгол Улсын бодлогын баримт бичгүүд, Олон улсын нэгдэн орсон 16 гэрээ, хэлэлцээр, конвенцод тусгагдсан оюуны өмчийг хамгаалах, урамшуулах бодлогыг хэрэгжүүлэхээр Патентын тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулиудын дагуу хэрэгжүүлж патент, гэрчилгээг олгож, эрхийн хамгаалалтыг хийж байна. Мөн дээрх хуулиудаас гадна Инновацийн тухай хууль, Технологи дамжуулах тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Оюуны өмчийн газар нь 1990-1996 оны хооронд Үндэсний хөгжлийн газрын харьяа Патент, барааны тэмдгийн газар, 1996-2016 он хүртэл Хууль зүй, Дотоод хэргийн яам, Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газар гэсэн статустай үйл ажиллагаагаа явуулж ирсэн. Мөн 2016 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газар нэртэйгээр Улсын бүртгэлийн байгууллагатай нэгтгэн зохион байгуулагдан үйл ажиллагаа явуулж байсныг Засгийн газрын “Засгийн газрын зарим агентлагийн талаар авах арга хэмжээний тухай” 175 дугаар тогтоолын дагуу Оюуны өмчийн газрыг дахин байгуулсан.

Патентын тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд 1963 оноос өнөөг хүртэл цаасан болон цахимаар шинэ бүтээлээр 6783, ашигтай загварын 4555, бүтээгдэхүүний загварын 4253 мэдүүлэгт дугаар олгон (2021 оны 10 сарын 4-ны байдлаар) хүлээн авсан байна. Цаасаар авсан мэдүүлгийг цахим мэдээллийн санд нэгтгэн хийх ажлыг амжилттай зохион байгуулж байна. Мөн Зөрчил шалган шийдвэрлэх хуулиар харьяалуулсан Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хянаж хуульд заасан хариуцлага, арга хэмжээг авч ажиллаж байна.

Монгол Улс Дэлхийн оюуны өмчийн байгууллагад 1979 онд элссэн бөгөөд Дэлхийн оюуны өмчийн байгууллагын олон улсын 16 гэрээнд нэгдэн орсон.

Оюуны өмчийн салбарын 2021-2025 оны хөгжлийн зорилтын 2021-2030 оны хөгжлийн төсөөллөөр Мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгож, оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлэхэд оюуны өмнө бүтээл туурвих, шинийг санаачлах үйл ажиллагааны эрх зүйн орчин, техник технологийг боловсронгуй болгож, оюуны өмчийн тогтолцоог хөгжүүлнэ, Дэлхийн өндөр хөгжилтэй орнууд оюуны өмчийг үндэсний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх хэрэгсэл, мэдлэгт суурилсан эдийн засгийн тулгын чулуу болгон ашигласан байдаг бөгөөд манай улс өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэхийн тулд “чанартай” патент, “хүчтэй” брэнд, соёл, урлагийн хосгүй бүтээл бүхий оюуны өмчийн тогтолцоог хөгжүүлэх нь зүйтэй байна. Мөн түүнчлэн оюуны өмчийн тогтолцоог хөгжүүлэх нь зөвхөн төрийн байгууллага, эсхүл оюуны өмчийн эрх эзэмшигчдэд хамааралтай бус, харин нийгэм, эдийн засгийн бүх салбарт хамаарах асуудал гэдгийг хүлээн зөвшөөрөх нийгмийн сэтгэл зүйг бүрдүүлэх явдал юм.

Оюуны өмчийн газрын 2020 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 1/458 дугаар албан бичгийн хавсралт 1 ёсоор бүтээл туурвих, шинийг санаачлах үйл ажиллагааг дэмжих тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр дараах ажлуудыг хийхээр төлөвлөн ажиллаж байгаа билээ. Үүнд:

- Оюуны өмчийн ашиглалтыг нэмэгдүүлэн үйлдвэрлэлд нэвтрүүлэх, эдийн засгийн эргэлтэд оруулах нөхцөлийг бүрдүүлэх,
- Ногоон оюуны өмчийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг хөхүүлэн дэмжих,
- Эдийн засгийн хувьд үр ашигтай оюуны өмчийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хамгаалах ажлыг дэмжин арга хэмжээ авах,
- Үндэсний болон орон нутгийн брэнд бий болгож хөгжүүлэх,
- Биет бус хөрөнгө болон оюуны өмчийг үнэлэх тогтолцоог бүрдүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд нэвтрүүлж хэвшүүлэх ажлууд орно.

Эдгээр ажлуудын хүрээнд байгууллагын 2021 оны төлөвлөгөөт ажил болох Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг эхлүүлэн патент эзэмшигчдийн төлөөллийг хамруулан Оюуны өмчийн бүтээл эдийн засгийн эргэлтэд орж үр ашиг хүртэж байгаа эсэхэд судалгаа хийж, эдийн засгийн эргэлтэд оруулахад тулгарч буй асуудлуудыг тодруулан, шийдвэрлэх боломжийг судлан бодлого боловсруулагчдад санал зөвлөмж хүргүүлэх, алдаршуулан сурталчилах, туршлага солилцох, цуглуулах, патент эзэмшигчдийн саналыг цуглуулах зорилгоор энэхүү судалгааны ажлыг хийлээ. Уг ажил жил бүр давталттайгаар хийгдэн цаашид улам сайжирч, оюуны өмчийн бүтээл эдийн засгийн эргэлтэд ороход чухал хувь нэмэр болж, байгууллагын хэтийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход дөхөм болно гэдэгт итгэлтэй байна.

Ажлын хэсгийн ахлагч, Оюуны өмчийн газрын
Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга С.Ганзориг

НЭГ. УДИРТГАЛ

1.1 ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 06 сарын 21-ний өдрийн А/150 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-ний 5 дугаар зүйлд Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг баталсан байна. Уг **төлөвлөгөөний “5.1 Оюуны өмчийн эдийн засгийн эргэлтэд оруулах хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, 5.2 Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулж буй хувь хүн, хуулийн этгээдийн судалгааг хийх”** заалт батлагдсан билээ. Энэхүү ажлын хүрээнд Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Оюуны өмчийн газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.7 дэх хэсгийг үндэслэн эдийн засгийн эргэлтэд орж буй шинэ бүтээл, түүний эзэмшигчийн судалгааг гаргаж, мэдээллийн сан үүсгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Оюуны өмчийн газрын даргын 2021 оны 09 сарын 28-ны өдрийн тушаалаар ажлын хэсгийн ахлагчаар С.Ганзориг (Захиргаа удирдлагын хэлтсийн дарга), гишүүдээр Б.Оргилмаа (Шинэ бүтээл, ашигтай загварын ахлах шинжээч), Б.Номиндарь (Бүтээгдэхүүний загварын шинжээч), Ц.Галцогт (Шинэ бүтээл, ашигтай загварын шинжээч), нарийн бичгийн даргаар Ц.Эрдэнэцэцэг (Шинэ бүтээл, ашигтай загварын шинжээч) нарын бүрэлдэхүүнтэй баг ажилласан.

Уг ажлын хэсэг дараах ажлуудыг хийхээр төлөвлөн 2021 оны 10 сарын 4-31-ны хугацаанд хийж гүйцэтгэлээ.

1. Судалгааны хүрээг тогтоох, төлөөлөл сонгох, түүвэр хийх,
2. Судалгааг хамрагдах хувь хүн, хуулийн этгээдийг шалгуур тавьж сонгох,
3. Санал асуулгын загвар гаргах, хянах, бэлэн болгох,
4. Асуулгын загварыг гүүгл форм дээр бэлтгэх,
5. Судалгаанд хамрагдагсдын жагсаалтыг гарган нэгтгэх, утсаар холбогдож патент эзэмшигчдийн болон албан тушаалтны холбоо барих утас, мэйл хаяг авах,
6. Судалгааг мэйл хаягаар линкийн хамт илгээх,
7. Ирсэн мэдээллийг хянах, нэгтгэх, алдаа заасан мэйлийг дахин явуулах,
8. Мэдээллийн санг нэгтгэх, цэвэрлэх,
9. Судалгаанд хамрагдагсдын патентын ангилалыг гаргах, давталтыг тоолох, жагсаалт хийх, орчуулах,
10. Оюуны өмчийн газрын мэдээллийн сангаас шаардлагатай мэдээллийг цуглуулах, нэгтгэх, график гаргах,
11. Судалгааны мэдээллийн баазад үр дүнгийн боловсруулалт хийх, шаардлагатай график гаргах,
12. Ажлын хэсгийн уулзалтуудыг хэсэгчилсэн болон нийт бүрэлдэхүүнтэй хийх,
13. Судалгааны тайлан боловсруулах, бичих, хүлээлгэн өгөх,

СУДАЛГАА ХИЙХ ХЭРЭГЦЭЭ, ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Оюуны өмчийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулж, үр өгөөжийг патент эзэмшигчид хүртэж байгаа эсэх, патентаа эзэмшсэнээр өөрийн эдийн засгийн чадавхиа нэмэгдүүлж байгаа эсэхийг судлах, өнөөгийн байдлыг судлах, мөн “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-ний 5 дугаар зүйлийн “5.1 Оюуны өмчийн эдийн засгийн эргэлтэд оруулах хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах ажлын бэлтгэлийг хангах чиглэлийн хүрээнд Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулж буй хувь хүн, хуулийн этгээдийн судалгааг хийх зайлшгүй хэрэгцээ шаардлага бий болсон. Мөн Оюуны өмчийн тухай хуулийн 20, 22 дугаар зүйлд Оюуны өмчийг үнэлэх үнэлгээний талаар заасан байгаа зэрэг хэрэгцээ .

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Патент эзэмшигчид хувь хүн, хуулийн этгээдийн төлөөллийг хамруулан Оюуны өмчийн бүтээл эдийн засгийн эргэлтэд орж үр ашиг хүртэж байгаа эсэхэд судалгаа хийж, эдийн засгийн эргэлтэд оруулахад тулгарч буй асуудлуудыг тодруулан, шийдвэрлэх боломжийг судлан бодлого боловсруулагчдад санал зөвлөмж хүргүүлэх улмаар алдаршуулан сурталчилах, туршлага солилцоход судалгааны зорилго оршино.

Дээрх судалгааны зорилгыг хангах үүднээс дараах зорилтуудыг дэвшүүлсэн.

Судалгааны зорилт

- Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчдээс хүчинтэй патенттай 100 хувь хүн, хуулийн этгээдийн төлөөллийг хамруулан судалгаа авах,
- Патент эзэмшигчдээс хувь хүн, хуулийн этгээдийн харьцааг 80/20 хувийн харьцаатай байхаар сонгох,
- Патент нь хүчинтэй хугацаатайг харгалзуулан сонгох,
- Судалгааны асуулгыг цомхон, өгөөжтэй хамрагдагсдын эдийн засгийн эрх ашгийг хөндөхгүйгээр боловсруулах,
- Гүүгл формоор судалгааг зохион байгуулан мэдээллийн баазыг бүрдүүлэх,
- Оюуны өмчийн мэдээллийн сангаас шаардлагатай мэдээллийг авч анализ, дүн шинжилгээ хийх
- Эзэмшдэг патентаа ашиглан эдийн засгийн эргэлтэд оруулж ашиг хүртэж чадаж байгаа эсэх, хүртдэг бол ямар хэлбэрээр хүртэж чадаж байгаа эсэх, чадахгүй байгаа бол шалтгааныг тодруулах,
- Патентдаа хөрөнгийн үнэлгээ хийлгүүлсэн эсэхийг тодруулах, боломжтой бол үнэлүүлсэн бүтээлийн тоо, үнийн дүнг авч, хэрхэн үнэлсэн эсэхийг судлах,
- Оюуны өмчийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулахтай холбоотой санал, хүсэлт байгаа эсэхийг судлан бодлого боловсруулагчдад санал, зөвлөмж хүргүүлэх,

1.2 СУДАЛГААНД АШИГЛАСАН АРГА ЗҮЙ

Энэхүү судалгааг зохион байгуулахдаа нийт патент эзэмшигчдээс шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар тус бүрээр бүлэг үүсгэн сонгож статистик тоон мэдээлэл болон холбогдох бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийх арга зүйг баримтлан ажилласан. Ингэхдээ асуулга, баримт бичиг, мэдээлийн сангийн судалгааны аргуудыг ашиглан мэдээлэл цуглуулж, нэгтгэн дүгнэлээ. Тус арга зүйгээр одоогийн бэлэн байгаа тоон болон баримт бичгийн мэдээллийг нэгтгэн, тэдгээрийг харьцуулан судалж, дүн шинжилгээ хийсэн болно.


Мөн Оюуны өмчийн бүтээлээ эдийн засгийн эргэлтэд оруулахтай холбоотой санал хүсэлтийг цуглуулан нээлттэй асуулттай асуумж боловсруулж, мэдээллийг нэгтгэн дүгнэлээ.

Тоон судалгаанаас гадна чанарын судалгааны арга хэрэглэсэн. Энэ арга нь судлаачдад асуудлыг гүн, нарийн олон талаас нь судлах боломжийг олгохоос гадна судалгааны шинэ санааг бий болгох нөөцийг бүрдүүлдэг. Чанарын судалгаа нь нээлттэй асуулттай ба энэ нь судалгаанд оролцогчдын санал бодол, сэтгэгдэл, туршлагыг илрүүлэх боломжтой байдаг учир асуулгын сэдвийн хүрээнд ганцаарчилсан ярилцлага, чөлөөт ярилцлага хийж патент эзэмшигчдийн үгийг сонсох, туршлага солилцох улмаар алдаршуулан сурталчилах зорилгоо биелүүлсэн.

1.3 СУДАЛГААНЫ АСУУЛГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Судалгааны асуулга нь нийт 6 асуултаас бүрдсэн бөгөөд патент эзэмшигчийн мэдээлэл, эдийн засгийн эргэлтэд оруулж үр ашгаа хүртэж чадаж байгаа болон чадахгүй байгаа эсэх, хөрөнгийн үнэлгээ хийсэн эсэхийг асуусан үндсэн асуулттай. Ингэхдээ эзэмшиж буй патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж үр ашгаа хүртэхдээ ямар хэлбэрээр, хүртээгүй байгаа бол ямар шалтгаанаар хүртэхгүй байгааг илрүүлэх зорилгоор асуусан асуулгатай. Мөн санал, хүсэлтийг нээлттэй асуусан асуумжтай.

Асуулгыг гүүгл форм ашиглан мэйлээр явуулж, мэдээллийг цуглуулсан бөгөөд патент эзэмшигчдийн мэйл хаягуудыг өөрсдөөс нь тодруулан линкээр илгээж буцаан цуглуулж авсан. Асуулга нь цөөн асуулттай учир оролцогчдоос цаг хугацаа их зарцуулахыг шаардаагүй байсан. Оролцогчдоос асуулга авах хэлбэрээр гомдол санал ирээгүй болно. Зарим олон патент эзэмшигчидтэй газрууд давхар мэйл хаяг өгсөн. Нийт 105 мэйлээр асуулгын линк илгээгдсэн.



Монгол Улсын Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг
ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗАР

Оюуны өмчийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг хүртэж буй талаарх судалгаа

Оюуны өмчийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашиг хүртэж байгаа эсэхэд судалгаа хийж, эдийн засгийн эргэлтэд оруулахад тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх, бодлого боловсруулагчдад санал хүргүүлэх, алдаршуулан сурталчлах, туршлага солилцох зорилгоор асуулга бэлтгэн танд хүргүүлж байна.

Патент эзэмшигч та энэхүү судалгаанд хамрагдан оюуны өмчийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа юм. Судалгааны мэдээллийг манай байгууллагын зөвхөн дотоод хэрэгцээнд ашиглах болно. Асуулгыг үнэн зөв бөгөж бидний ажилд туслана уу.

Email *

Valid email

.....

This form is collecting emails. [Change settings](#)

1. Патент эзэмшигчийн нэр? *

Short answer text

.....

2. Та хамгаалагдсан патентаа ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг нь хүртэж байна уу?

	Шинэ бүтээл	Ашигтай загвар	Бүтээгдэхүүний загвар
Тийм	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
Үгүй	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

3. Хэрэв тийм бол ямар хэлбэрээр үр ашиг хүртэж байгаа вэ?

1.4 СУДАЛГААНД ХАМРАГДАГСАД

Оюуны өмчийн тухай хуулийн 7.1 д аж үйлдвэрийн өмчийн эрхэд дараах зүйл хамаарна хэмээн заасан байдаг.

- 7.1.1. шинэ бүтээл
- 7.1.2. ашигтай загвар
- 7.1.3. бүтээгдэхүүний загвар
- 7.1.4. барааны тэмдэг
- 7.1.5. газар зүйн заалт

Эдгээрээс ажлын хэсгийн тушаалын дагуу аж үйлдвэрийн өмчийн эрхийн шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчдийг энэхүү судалгаанд хамрууллаа.

Судалгаанд хүчинтэй байгаа шинэ бүтээлийн 129, ашигтай загварын 601, бүтээгдэхүүний загварын 435 патент эзэмшигчдээс хамгийн олон бүтээлийн патент эзэмшигч сонгох эхний шалгуурыг тавьсан бөгөөд шинэ бүтээлийн 50, ашигтай загварын 20, бүтээгдэхүүний загварын 30 хуулийн этгээд, хувь хүнийг сонгосон.

Ингэхдээ шинэ бүтээл 20 жил, ашигтай загвар 7 жил, бүтээгдэхүүний загвар 10 жилийн хугацаанд эрх нь хүчинтэй, мөн эрх нь хамгаалагдсан патент эзэмшигчдийг хамруулсан. (Хуучин патентын хуулиар) Эдгээрээс аж үйлдвэрийн өмчийн 3 бүтээл тус бүрээр сонголтын давхардал үүссэн 6 хуулийн этгээд байсныг нэгтгэн нийт 94 хувь хүн, хуулийн этгээдийг судалгаанд хамруулсан.

Судалгаанд хамрагдагсдын 210 шинэ бүтээл, 247 ашигтай загвар, 221 бүтээгдэхүүний загварын, нийт 678 хүчинтэй патент байна.

Зураг 2 Судалгаанд хамрагдагсад, патентын тоогоор



Судалгаанд хамрагдагсад нийтдээ 1165 шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын 1165 патенттай байна. Эдгээрээс 7 нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар тус бүр патенттай, 21 нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар 2 дээр патенттай, 66 нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар тус бүр дээр патенттай байна.

Судалгаанд хамрагдагсдын 82 буюу 87,0% нь хуулийн этгээд, 12 буюу 13,0% нь хувь хүн байна.

Хүснэгт 1 Судалгаанд хамрагдсан хуулийн этгээд, хувь хүний тоо, хувь байршлаар, аймаг, дүүргээр

Нийслэл/Дүүрэг	Нийт тоо	Үүнээс			
		Хуулийн этгээд		Хувь хүн	
		Тоо	Хувь	Тоо	Хувь
Улаанбаатар	82	73	89,0%	9	75,0%
Баянхонгор	1	-	-	1	8,3%
Говьалтай	1	1	1,2%	-	-
Говьсүмбэр	1	1	1,2%	-	-
Дархан-Уул	2	2	2,4%	-	-
Орхон	2	2	2,4%	-	-
Өвөрхангай	1	-	-	1	8,3%
Өмнөговь	2	2	2,4%	-	-
Сүхбаатар	1	-	-	1	8,3%
Хөвсгөл	1	1	1,2%	-	-
Нийт	94	82	100%	12	100%

Судалгаанд хамрагдсан патент эзэмшигчдийн ихэнх нь буюу нь 84 (87,5%) нь Улаанбаатарт, 12 (12,5%) нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулдаг байна.

Зураг 3 Судалгаанд хамрагдагсдын байршил, нутаг, дэвсгэрээр



Патентын тоог нутаг дэвсгэрийн хувьд авч үзэхэд Улаанбаатар хотод 614 (92,0%) үлдсэн 64 (9,4%) нь хөдөө орон нутгийнх байна. Патентын тоогоороо хамгийн олон буюу 181 (26,6%) нь Сүхбаатар дүүрэг, 167(24,6%) нь Баянзүрх дүүргийнх байхад, орон нутгаас Дархан-Уул аймагт 17 патент байна.

Судалгаанд хамрагдагсдыг шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвараар авч үзэхэд нийслэлийн дүүргүүд ихэнх патентыг эзэлж байгаа ба Баянзүрх дүүрэг бүтээгдэхүүний загварын 81 патент буюу нийслэлийн бүтээгдэхүүний загварын 36,9%-ийг, Дархан-Уул аймаг 17 буюу ашигтай загварын аймгуудынхаа 40,4%-ийг, Сүхбаатар дүүрэг 79 буюу 39,5%-ийн патент


эзэмшиж байна. Эдгээрээс хувь хүн, хуулийн этгээдээр онцлоход олон патент эзэмшдэг томоохон хувь хүн, хуулийн этгээд эдгээр дүүрэг, аймагт олноор байдагтай холбоотой байна.

Хүснэгт 2 Патентын тоо, шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, аймаг, дүүргээр

Аймаг/дүүрэг	Шинэ бүтээл	Ашигтай загвар	Бүтээгдэхүүний загвар	Нийт
Багануур	1			1
Баянгол	5	21	20	46
Баянзүрх	43	43	81	167
Сонгинохайрхан	12	24	25	61
Сүхбаатар дүүрэг	79	71	31	181
Хан-Уул	33	44	56	133
Чингэлтэй	27	2	6	35
Баянхонгор		5		5
Говь-Алтай			1	1
Говьсүмбэр	1			1
Дархан-Уул		17		17
Орхон	4	3		7
Өвөрхангай		4		4
Өмнөговь		7	1	8
Сүхбаатар аймаг		5		5
Хөвсгөл	5	1		6
Нийт	210	247	221	678

Судалгаанд хамрагдагсдыг шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патентын тоогоор эрэмбэлэн авч үзэхэд Сүхбаатар дүүрэг шинэ бүтээлийн 79, ашигтай загварын 71, бүтээгдэхүүний загварын 31 патенттай байна. Дүүргүүдээс Налайх, аймгуудаас 12 аймаг уг судалгааны олон патент зэмшигч байх шалгуурыг хангаагүй байна.

Зураг 4 Патентын тоо, шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, аймаг, дүүргээр



Хамгийн олон бүтээлээр эрхийн хамгаалалт хийлгэсэн хуулийн этгээд МУИС (57 патент) байдаг байхад хувь хүмүүсээс хөдөө аж ахуйн чиглэлээр олон патент эзэмшдэг А.Чойжамц (хүчинтэй байгаа 14) гэсэн иргэн байна.

Шинэ бүтээлээр МУИС 44 патент, ашигтай загвараар Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг 27, бүтээгдэхүүний загвараар Байгаль Хаус ХХК 41 патент тус тус эзэмшиж байна.



Судалгаанд үндэсний томоохон үйлдвэрлэгчид, судалгаа шинжилгээний томоохон хүрээлэн, хүнс үйлдвэрлэгч, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, татвар төлөгч томоохон байгууллагууд, банк санхүүгийн байгууллагууд, их сургуулиуд болон бусад хувь хүн, хуулийн этгээд, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн төлөөллийг бүрэн хамарсан төлөөлөх чадвар сайтай түүвэр болсон байна. Энэ нь судалгааны гол зорилго болох оюуны өмчийн бүтээлээ эдийн засгийн эргэлтэд оруулан үр ашгаа дээшлүүлж буй эсэхэд хариулт өгөх бүрэн боломжтой төлөөлөл болсон байна. Хамрагдагсдаас эрхэлдэг үйл ажиллагааны чиглэлээр нь томоохон, олон улсад бүтээгдэхүүнээ гаргадаг, томоохон, олон ажлын байртайгаас зэргээр нь онцлон авч үзвэл 3 Их сургууль (ШУТИС, МУИС, ХААИС), 13 хүрээлэн (ХААИС-ийн харъяа Ургамал газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн, Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн, ШУА, Физик Технологийн Хүрээлэн, Эм судлалын хүрээлэн, Биологийн хүрээлэн, Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн, Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн, Мал эмнэлгийн хүрээлэн, ШУА, Ерөнхий болон Сорилын Биологийн Хүрээлэн, ШУА, Хими, Химийн Технологийн Хүрээлэн, Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн), 10 хүнсний томоохон үйлдвэрлэгч (Хатан сүйх, ТЭСО ХХК, Айсмарк, Газар шим, Витафит, Талх чихэр, Атар өргөө ХХК, Өгөөж ХХК, Сүү ХХК, АПУ ХХК, Их тайга ХХК), 1 сан (Сарангэрэл), гоо сайхан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 4 (Монкрем, Монос косметикс, Монос хүнс, Монгол давсан урлал, Монхимо), үндэсний тэргүүлэгч үйлдвэрлэл явуулдаг 7 хуулийн этгээд (Улаанбаатар төмөр зам, Шивээ Овоо, Таван богд, Эрдэнэт үйлдвэр, 4 дүгээр цахилгаан станц, Таван толгой түлш), 3 эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэгч Монос, Тавин ус, Монхимио, 2 банкны үйлчилгээ эрхэлдэг (Голомт, Худалдаа хөгжлийн банк) зэрэг үндэсний чиглэл бүрийн томоохон төлөөлөл багтсан байна. Эндээс үзэхэд судалгаанд хамрагдагсдын 43,0% хувийг томоохон байгууллагууд эзэлж байгаа нь тэд оюуны өмчийн эрхийн хамгаалалтаа сайн хийдэг, патентаа хамгаалуулах хэрэгцээ шаардлага их байдгийг илтгэж байна.

Судалгаанд хамрагдагсдын патентыг олон улсын ангилалаар ангилан авч үзэхэд **шинэ бүтээл, ашигтай загварын хувьд** хүний хэрэгцээг хангах зүйлс 57(36,5%), хими төмөрлөг 37 (23,7%), технологийн төрөл бүрийн арга 20(12,8%), механик, гэрэлтүүлэг, дулаан, шахуурга, хөдөлгүүр, зэвсэг, тэсрэх бодис 10(6,4%), цахилгаан, физик, барилга-уул уурхайн ангилалых тус бүр 9(5,7%), нэхмэлийх 5(3,2%) байна.

Зураг 5 Судалгаанд хамрагдагсдын шинэ бүтээл, ашигтай загварын патентыг ангиллалаар харуулсан байдал



Шинэ бүтээл, ашигтай загварын патентын ангилалаас хүний хэрэгцээг хангах зүйлс 36,5% хувь буюу бусад ангиллаас хамгийн их хувийг эзэлж байна. Харин нэхмэлийн ангилал хамгийн бага буюу 3,2%-ийг эзэлж байна. Эндээс дүгнэхэд судалгаанд хамрагдагсдын хийсэн бүтээлийн дийлэнх буюу 36,5% нь хүний хэрэгцээг хангах зүйлсийн ангилалд хамаарах шинэ бүтээл, ашигтай загварын патенттай байна.

Бүтээгдэхүүний загварын судалгаанд хамрагдагсдыг ангилалаар авч үзэхэд нийт 26 ангилалаар патент авсан аж ахуй нэг иргэн байна.

Бүтээгдэхүүний загварын олон улсын Лакорногийн 32 ангилал байдаг бөгөөд энэ ангилалаар судалгаанд хамрагдагсдын патентыг ангилан авч үзье. Судалгаанд хамрагдагсдыг патентын ангилалаар хамгийн их нь 19-08 болох бусад хэвлэмэл зүйлс, шошгийн ангилал хамгийн их 22 буюу нийт ангилалын 30,1%-ийг эзэлж байна. Харин 09-03 болох хайрцаг, гэр, сав, ундааны болон консервны лаазны ангилал 12 буюу нийт ангилалын 16,4%-ийг эзэлж байна.

Хүснэгт 3 Судалгаанд хамрагдагсдын бүтээгдэхүүний загварын патентын тоо, ангилалаар

Ангиллын код	Патентын тоо	Тайлбар	Ангилал	
01-01	1	Талх, нарийн боов, жигнэмэг, гурилан бүтээгдэхүүн, гоймон болон үр тарианы бусад бүтээгдэхүүн, шоколад, амттан, мөс	Хүнсний бүтээгдэхүүн	1
02-02	5	Хувцас	Хувцас ба бусад жижиг тоноглол	9
02-04	2	Гутал, оймс		
02-05	1	Зангиа, ороолт, алчуур, хамрын алчуур		
02-07	1	Хувцасны жижиг тоноглол болон аксессуар		
03-01	1	Аяны авдар, чемодан, бичгийн цүнх, гар цүнх, түлхүүрийн гэр, төрөл бүрийн зориулалттай сав, гэр, түрийвч болон адил төрлийн бүтээгдэхүүн	Аяллын зориулалттай бүтээгдэхүүн, уут, гэр, шүхэр болон бусад ангилалд ороогүй хувийн эд зүйл	1
04-02	1	Хувийн хэрэглээний сойз, хувцасны сойз болон гутлын сойз	Сойзон бүтээгдэхүүн	1
05-05	1	Даавуу	Сүлжмэл бүтээгдэхүүн, хиймэл болон байгалийн гаралтай материал	1
06-03	1	Ширээ болон энэ төрлийн тавилга	Тавилга	2
06-05	1	Ком тавилга		
07-01	2	Шаазан эдлэл, шилэн эдлэл, таваг болон ижил төрлийн бусад зүйлс	Бусад ангилалд ороогүй ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн	2
09-01	3	Лонх, жижиг шилэн сав, хоолны хувин, сүлжмэл бүрээстэй лонх болон динамик тугнагчтай сав	Ачааг тээвэрлэх болон ачиж, буулгах зориулалттай сав, баглаа боодол	16
09-03	12	Хайрцаг, гэр, сав, ундааны болон консервны лааз		
09-07	1	Таглаж, бөглөх зүйл болон бусад		
11-01	2	Үнэт эдлэл		
11-02	5	Түлхүүрийн оосорны чимэглэл, ширээний, камин болон ханын чимэглэл, цэцгийн ваар болон сав	Гоёл чимэглэлийн зүйлс	10
11-03	1	Медаль болон энгэрийн ялгах тэмдэг		
11-05	1	Туг, баяр ёслолын чимэглэл		
11-09	1	Гоёл чимэглэлийн зүйлс		
19-01	1	Бичгийн цаас, шуудангийн ил захидал	Бичиг хэргийн болон оффисын зүйлс ба хэрэгсэл, зургийн болон сургалтын материал ба хэрэгсэл	24
19-06	1	Бичих, зурах, будах, уран баримал, сийлбэрийн болон бусад уран сайхны бүтээлд зориулсан материал, хэрэгсэл		
19-08	22	Бусад хэвлэмэл зүйлс/шошго/		
21-01	3	Жижигрүүлсэн тоглоом наадгай		
23-03	1	Халаалтын тоног хэрэгсэл	Худалдаа болон сурталчилгааны тоног хэрэгсэл, тэмдэг	6
25-01	1	Барилгын материал		
29-02	1	Ослоос урьдчилан сэргийлэх, аврах зориулалттай төхөөрөмж, хэрэгсэл (бусад ангилалд ороогүй)		
Нийт				73

Бүтээгдэхүүний загварын олон улсын Лакорногийн ангилалаар ерөнхийгөөр нь судалгаанд хамрагдагсдын ангилалыг эрэмбэлэн авч үзэхэд 59 нь буюу 80,8% нь хувцас ба бусад жижиг тоног хэрэгсэл, тэмдэг ангиллын патентыг судалгаанд хамрагдагсад эзэмшдэг байна.

Зураг 6 Сүдалгаанд хамрагдагсдын бүтээгдэхүүний загварын патент, эрэмбэлснээр



ХОЁР. ПАТЕНТЫН МЭДЭЭЛЛИЙН САНД БҮРТГЭГДСЭН БҮТЭЭЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Засгийн газрын 2012 оны 101 дүгээр тогтоолоор баталсан “Цахим засаг” үндэсний хөтөлбөр болон ДОӨБ-тай байгуулсан “Мэдээллийн технологийн чиглэлээр хамтран ажиллах тухай гэрээ”-ний хүрээнд Монгол Улсад эрхийн хамгаалалт хийгдсэн барааны тэмдгийн мэдээллийн санг WIPO PUBLISH системийг ашиглан Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын Дэлхийн брэндийн мэдээллийн сантай (Global Brand Database), Монгол Улсад эрхийн хамгаалалт хийгдсэн бүтээгдэхүүний загварын мэдээллийн санг Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын Дэлхийн дизайны мэдээллийн сантай холбох ажлыг зохион байгуулсан.

“Цахим засаг” үндэсний хөтөлбөрийн “Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй болгох” зорилтын хүрээнд барааны тэмдгийн эрхийн хамгаалалтын үйл ажиллагааг илүү хяналттай, өндөр бүтээмжтэй болгох зорилгоор ДОӨБ-ын WIPO IPAS /Аж үйлдвэрийн өмчийн удирдлагын систем/ системийг суурилуулж, 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж эхлээд байна.

Оюуны өмчийн аж үйлдвэрийн өмчийн цахим сан болох PUBLISH.IPOM.MN системд 1963 оноос хойш эрхийн хамгаалалт хийгдсэн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загвар, үндэсний болон олон улсын барааны тэмдэг, газар зүйн заалтын мэдээллийн санг цахимжуулж олон нийтэд нээлттэй болгосон. Мөн EFILING.IPOM.MN цахим мэдүүлгийн системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нар 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн ашиглаж байна.

Оюуны өмчийн мэдээллийн сангаас аж үйлдвэрийн өмчийн шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын зарим мэдээллийг сонгон авч нэгтгэлээ. Мэдээллийн эх сурвалжийг зарим тохиолдолд мэдээллийн сангийн системээ ялгахын тулд IPAS, IPOM publish гэж тэмдэглэлээ.

2.1 МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ЗАРИМ МЭДЭЭЛЭЛ

Оюуны өмчийн мэдээллийн санд шинэ бүтээлээр 5996, ашигтай загвараар 4527, бүтээгдэхүүний загвараар 3674, нийт 14197 мэдүүлэг байна. (2021 оны 10 сарын 4-ны байдлаар) Нийт мэдүүлгийн 42,2% -ийг шинэ бүтээл, 31,8%-ийг ашигтай загвар, 25,8%-ийг бүтээгдэхүүний загвар эзэлж байна.


Хүснэгт 4 Патентын тоо, хувиар (Нийт болон хүчинтэй)

	Нийт мэдүүлгийн тоо		Үүнээс Хүчинтэй
	Тоо	Хувь	
Шинэ бүтээл	5996	42,2%	1393
Ашигтай загвар	4527	31,8%	1045
Бүтээгдэхүүний загвар	3674	25,8%	654
Нийт	14197	100%	3082

Хүчинтэй патентыг 2021 оны 10 сарын 4-ны байдлаар авч үзвэл шинэ бүтээлийн 1393, ашигтай загварын 1045, бүтээгдэхүүний загварын 654 патент хүчинтэй эрх нь хамгаалагдаж байна.

Хүчинтэй патентын тухайд сүүлийн 10 жилээр авч үзвэл хамгийн их нь 2020 онд ашигтай загварын (197), 2015 онд шинэ бүтээлийн (180), 2019 онд шинэ бүтээлийн (177), ашигтай загварын (178) патент байна. Сүүлийн 10 жилийн дунджаар авч үзвэл шинэ бүтээлээр 131, ашигтай загвараар 145, бүтээгдэхүүний загвараар 102 патент хүчинтэй байсан байна. (2021 оныг 10 сарын 4-ны байдлаар оруулав.)

Зураг 7 Хүчинтэй патентын тоо, шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, оноор



Хүснэгтээс харахад сүүлийн 3 жилийн хугацаанд хүчинтэй шинэ бүтээлийн тоо тогтмол өссөн байхад, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар буурсан үзүүлэлттэй байна. 2021 оны 10 сарын патентын тоог урьд оны энэ үетэй харьцуулахад хүчинтэй патентын тоо өссөн байна.

Мэдүүлгийг цаасаар Оюуны өмчийн газар хүлээн авахаас гадна 2018 оноос цахимаар хүлээн авдаг болсон. Ингэснээр үйл ажиллагаа хялбар, хэмнэлттэй болж, цаг хугацаа, нууцлал, хяналт сайжирсан бөгөөд 2021 оны 10 сарын 04-ны хооронд 359 мэдүүлэг ирсэн байна.

Хүснэгт 5 Цахимаар ирсэн патентын мэдүүлгийн тоо

	2018 он	2019 он	2020 он	2021/10/04
Шинэ бүтээл	32	59	80	60
Ашигтай загвар	8	13	17	22
Бүтээгдэхүүний загвар	1	8	13	46
Нийт	41	80	110	128

Цахимаар ирэх мэдүүлгийн тоо жил ирэх тусам өссөн байна. Жилд дунджаар 90 гаруй мэдүүлэг цахимаар ирсэн байна.


1979 оноос эхлэн гадаад улс орнуудаас шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгүүд ирсэн байна. Сүүлийн жилүүдэд мэдүүлгийн тоо өсөх хандлагатай байна. 2011 оноос хойш буюу сүүлийн 10 жилийн байдлаар авч үзэхэд 19 улс орноос мэдүүлэг ирсэн ба Монгол улс 1789, АНУ 230, Герман 118, БНХАУ 101, бусад улсууд 100-аас бага тоотой мэдүүлэг ирүүлжээ.

Хүснэгт 6 Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийн тоо, улс, оноор

Улс	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021/10/4	Нийт
AU Австрали	5	2	15	12	13	8	1	1	2	5	4	68
BR Бразил		1	1	1	1	1		1		1	1	8
CA Канад	1		3	1	1	3	1		3		1	14
CH Швейцарь	2	1	3	1	1	2		1	4		2	17
CN БНХАУ	2	3	5	17	11	9	9	8	10	10	17	101
DE ХБНГУ	14	8	30	16	16	11	6	2	5	5	5	118
ES Испани						1	3		1	1	1	7
FI Финлянд	2	1	7	7	8	9	3		1	2	2	42
FR Франц		2	3	6	5	5	1	2	4	2	1	31
GB Англи		2	1	3	5	2			3	4	3	23
IE Ирланд											2	2
IT Итали	1				2		2	1		1	2	9
JP Япон	2	2	4	4	3	7	6	2	10	5	3	48
KR Солонгос	2	2	8	2	7	12	6		1	7	14	61
MN Монгол	84	88	131	173	201	193	211	164	245	241	58	1789
NL Нидерланд		7	1	5	1	2	1		1	2	1	21
RU Орос		1		2	1			2	2	3	3	14
SE Швед											2	2
US АНУ	8	12	21	29	26	20	11	3	43	27	30	230
Нийт	2134	2144	2246	2293	2317	2301	2278	2205	2354	2336	2173	2605

Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг улс орны хувьд сүүлийн 10 жилд тогтмол 2100-2400 гийн хооронд ирсэн байна. Улсуудын хувьд ч мэдүүлэг өгдөг идэвхтэй улс орнууд жил бүр адил тооны мэдүүлэг илгээдэг байна. Монгол улсын тоог хасаж тооцоход нийт гадаад улс орнуудаас хамгийн их нь АНУ 230, нийт гадаад улсуудын мэдүүлгийн 28,1%, ХБНГУ 14,4%, БНХАУ 12,3% тус тус эзэлж байна. Улс орнуудын мэдүүлгийн тооны эзлэх хувийг дараах зурагт үзүүлэв.

Зураг 8 Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийн тоо, улс, хувиар



2.2 ШИНЭ БҮТЭЭЛ

Шинэ бүтээлийн 5996 мэдүүлэг Оюуны өмчийн мэдээллийн санд байгаа бөгөөд эдгээрийн 3554 буюу 59,2% нь дотоодын, 2442 буюу 40,7% нь гадаадын мэдүүлэг байна. 1963 оноос 2021 оны 10 сарын 4-ны өдрийг хүртэл оноор жагсааж дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 7 Шинэ бүтээлийн патентын мэдүүлгийн тоо, оноор


Он	Нийт	Үүнээс	
		Дотоод	Гадаад
1963	3	3	
1965	6	6	
1966	4	4	
1967	5	5	
1968	13	13	
1969	5	5	
1970	13	13	
1971	10	10	
1972	10	10	
1973	7	7	
1974	8	8	
1975	18	18	
1976	26	26	
1977	17	17	
1978	23	23	
1979	52	52	
1980	48	48	
1981	34	34	
1982	21	21	
1983	18	18	
1984	29	29	
1985	31	31	
1986	30	30	
1987	30	30	
1988	52	52	
1989	44	44	
1990	54	53	1
1991	106	103	3
1992	107	98	9
1993	102	96	6
1994	120	107	13
1995	124	98	26
1996	112	85	27
1997	188	162	26
1998	150	108	42
1999	170	110	60
2000	156	62	94
2001	193	75	118
2002	181	86	95
2003	204	120	84
2004	193	105	88
2005	193	92	101
2006	195	96	99
2007	188	80	108
2008	150	76	74
2009	143	71	72
2010	174	94	80

2011	209	71	138
2012	230	76	154
2013	268	129	139
2014	249	118	131
2015	233	108	125
2016	221	111	110
2017	225	110	115
2018	160	82	78
2019	170	85	85
2020	148	66	82
2021/10/04	123	64	59
Нийт	5996	3554	2442

Шинэ бүтээлийн нийт патентын мэдүүлгийн 4413 буюу 73,5%-д нь патент олгогдсон байна. Үүнээс 2398 (54,3%) нь дотоодын, 1851 (41,8%) нь РСТ, 163 (3,6%) нь Парисын конвенцийн дагуу давамгайлах эрх үүсч патент олгогдсон байна.

Шинэ бүтээлийн нийт патентын мэдүүлгийн 5279 буюу 88,0% буюу нь 1992 оноос энэ оныг хүртэл ирсэн байгаа бөгөөд патент олгосон байдлыг авч үзвэл 4413 буюу 1992-2021 оны 10 сарын 4-ны хүртэлх нийт патентын 83,5% нь патент эзэмших эрхээ авсан байна.

Зураг 9 Шинэ бүтээлийн нийт мэдүүлгийн болон олгосон патентын тоо



1991 оноос мэдүүлгийн тоо өссөн бөгөөд эдгээр жилүүдэд дунджаар жилд 176 шинэ бүтээлийн мэдүүлэг ирсэн байна. Шинэ бүтээлийн патентын мэдүүлэг 2011-2017 онуудад хамгийн их байсан бөгөөд эдгээр жилүүдэд дунджаар 233 ирсэн байна. 2013 онд хамгийн их буюу 268 патентын мэдүүлэг иржээ. Патентын мэдүүлгийн тоо өсөлт бууралттай байгаа шалтгааныг цаашид нарийвчлан судалж, нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах хэрэгцээ байгаа нь харагдаж байна.

Патент олгосон байдлыг авч үзэхэд мэдүүлгийн тооноос хамааран патент олгогддог болох нь харагдаж байна. Мэдүүлгийн тоотой олгосон патентын тоо харилцан хамааралтай байна.

2.3 АШИГТАЙ ЗАГВАР

Ашигтай загварын патентын мэдүүлгийг 1999 оноос авч эхэлсэн бөгөөд 4527 мэдүүлэг Оюуны өмчийн мэдээллийн санд байгаа бөгөөд эдгээрийн 4507 буюу 99,5% нь дотоодын, 20 буюу 0,4% нь гадаадын мэдүүлэг байна. 1999 оноос 2021 оны 10 сарын 4-ны өдрийг хүртэлх ашигтай загварын патентын мэдүүлгийн тоо, олгосон патентын тоог оноор жагсаавал дараах байдалтай байна.

Хүснэгт 8 Ашигтай загварын патентын мэдүүлгийн тоо, оноор


Он	Нийт мэдүүлгийн тоо	Үүнээс		Он	Олгосон патентын тоо	Үүнээс	
		Дотоод	Гадаад			Дотоод	Гадаад
1999	30	30					
2000	273	273		2000	271	271	
2001	221	221		2001	193	193	
2002	316	316		2002	187	187	
2003	293	293		2003	220	219	1
2004	367	367		2004	235	229	6
2005	238	238		2005	213	213	
2006	199	199		2006	148	146	2
2007	144	144		2007	127	124	3
2008	180	180		2008	142	142	
2009	119	119		2009	108	108	
2010	129	128	1	2010	98	97	1
2011	118	118		2011	75	73	2
2012	122	115	7	2012	88	80	8
2013	156	155	1	2013	120	119	1
2014	194	192	2	2014	126	125	1
2015	148	148		2015	135	134	1
2016	203	201	2	2016	137	137	
2017	262	262		2017	164	164	
2018	221	221		2018	140	140	
2019	223	220	3	2019	178	176	2
2020	223	220	3	2020	197	193	4
2021/10/04	148	147	1	2021/10/04	86	85	1
Нийт	4527	4507	20	Нийт	3388	3355	33

Ашигтай загварын нийт мэдүүлгийн 3388 буюу 74,8%-д нь гэрчилгээ олгогдсон байна. Үүнээс 3355 (99,0%) нь дотоодын, 33 (1,0%) нь гадаадын мэдүүлэгт олгогдсон байна.

Ашигтай загварын мэдүүлэг 2002-2005 онуудад эрчимтэй (1214 мэдүүлэг ба нийт мэдүүлгийн 26,8%), 2017 оноос хойш тасралтгүй өссөн (жилд дунджаар 226 мэдүүлэг) үзүүлэлттэй байгаа нь хүснэгтээс харагдаж байна. 2002 онд 316, 2004 онд хамгийн их буюу 367 мэдүүлэг тус тус иржээ.

Патентыг 2000 оноос хойш жилд дунджаар 161 мэдүүлэгт олгосон байна.

Зураг 10 Ашигтай загварын патентын мэдүүлгийн болон олгосон патентын тоо



2.4 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАР


Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг 1965 оноос авч эхэлсэн бөгөөд Оюуны өмчийн мэдээллийн санд 8617 мэдүүлэг байна. Эдгээрийн 3518 нь үндэсний, 5099 олон улсын бүртгэлийн тухай Гаагийн хэлэлцээрийн дагуу Монгол улсын нэр зааж бүртгэгдсэн гадаадын патентын мэдүүлэг байна. Үндэсний мэдүүлгийн 3332 буюу (38,65%) нь дотоодын, 186 буюу (2,1%) нь гадаадын патентын мэдүүлэг байна.

Хүснэгт 9 Бүтээгдэхүүний загварын мэдүүлэг ба олгосон патентын тоо, оноор

Он	Мэдүүлгийн тоо				Олгосон патентын тоо			
	Үндэсний		Гааг /Nauge/	Нийт	Үндэсний		Гааг /Nauge/	Нийт
	Дотоод	Гадаад			Дотоод	Гадаад		
1965	7			7	1			1
1968	41			41	1			1
1976				0	3			3
1978	15			15	2			2
1979	1			1	1			1
1982	1			1	1			1
1983	7			7	3			3
1984	1			1	5			5
1985	9			9	10			10
1986	8			8	8			8
1987	36			36	35			35
1988	50			50	81			81
1989	10			10	28			28
1990	28			28	23			23
1991	83			83	65			65
1992	83			83	76			76
1993	71			71	82			82
1994	120	1		121	89			89
1995	150			150	156	1		157
1996	124	4		128	128	4		132
1997	74	1	177	252	80		177	257
1998	65	5	284	354	88	6	284	378
1999	34	7	244	285	31		244	275
2000	47	2	307	356	38	9	307	354
2001	81		307	388	64		307	371
2002	75	1	381	457	74	1	381	456
2003	104	11	307	422	98	3	307	408
2004	100	6	252	358	85	10	252	347
2005	142	7	208	357	148	7	208	363
2006	115	10	213	338	121	13	213	347
2007	65	8	200	273	93	4	200	297
2008	87	11	249	347	89	14	249	352
2009	54	12	159	225	56	13	159	228
2010	89	1	169	259	45		169	214
2011	81	6	151	238	96	4	151	251
2012	90	11	177	278	59	2	177	238
2013	119	9	231	359	91	8	231	330
2014	127	5	185	317	69	11	185	265
2015	122	6	241	369	74	2	241	317
2016	125	9	140	274	127	8	140	275
2017	163	9	127	299	89	12	127	228
2018	140	38	97	275	105	16	97	218
2019	180	2	140	322	112	28	140	280
2020	168	4	107	279	101	1	107	209
2021	40		46	86	71		46	117
Нийт	3332	186	5099	8617	2902	177	5099	8178


Бүтээгдэхүүний загварын патентын үндэсний мэдүүлгийн 3079-д нь патент олгогдсон байна. Үндэсний патентын дотоодын 2902 нь гадаадын 177, Гаагийн хэлэлцээрийн дагуу Монгол улсын нэр зааж бүртгэгдсэн гадаадын патентын мэдүүлэгт 5099 патент олгогдсон байна.

Зураг 11 Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийн тоо, оноор



Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг 1965 оноос эхэлсэн бөгөөд 1991 оноос үндэсний мэдүүлгийн тоо өссөн бөгөөд 1997 оноос эхлэн Гаагийн мэдүүлэг тасралтгүй өссөн байна. 1991 оноос одоог хүртэлх хугацаанд бүх мэдүүлгийн 8403 буюу 94,5% нь ирсэн байна. 2017 онд 163, 2020 онд хамгийн их буюу 180 дотоодын бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг иржээ.

Зураг 12 Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийн болон олгосон патентын тоо



Бүтээгдэхүүний загварын үндэсний мэдүүлэг 1994 оноос ихээхэн өссөн бөгөөд жилд дунджаар 186 мэдүүлэг патент хүссэн байна. Патент олгосон байдал нь мэдүүлгийн тоотой адил шугаман хамааралтай байна.

2.5 ОЛОН УЛСЫН АНГИЛАЛ

Шинэ патентийн тухай хуульд 3.1.13.“патентын олон улсын ангилал” гэж 1971 оны Патентын олон улсын ангиллын тухай Страсбургийн хэлэлцээрээр баталж, нэмэлт, өөрчлөлт оруулсан Патентын олон улсын ангилалыг ойлгоно гэж заасан байдаг.


Оюуны өмчийн мэдээллийн сангаас шинэ бүтээл, ашигтай загварын нийт патентыг ангилалаар авч үзэхэд (IPOM publish) химийн ангилалд 2909 буюу нийт ангилалын 39,9%, механикийх 1630(22,1%), тоног төхөөрөмжийх 780(10,5%), цахилгааных 331(4,4%) тус тус эзэлж байна.

Хүснэгт 10 Шинэ бүтээл, ашигтай загварын патентын ангилал, тоо, хувиар

	Ангилал	Патентын ангилалын тоо	Хувь
1	Хими	2909	39,4%
2	Цахилгаан	331	4,4%
3	Тоног төхөөрөмж	780	10,5%
4	Механик	1630	22,1%
5	Бусад	774	10,4%
6	Ангилалдаагүй	951	12,8%
	Нийт	7375	100%

Шинэ бүтээл, ашигтай загварын ангилалаас үзэхэд химийн ангилал нийт бүтээлийн 39,4%-ийг эзэлж байна. Эндээс үзэхэд химийн шинэ бүтээл, ашигтай загварын оюуны бүтээл эрхлэгчид ихээхэн бүтээл хийж патентаа авч эрхээ хамгаалуулдаг нь харагдаж байна. Энэ чиглэлийн судалгааг байнга хийж, ямар чиглэлийн хэрэгцээ шаардлага нийгэмд үүсээд бүтээл ихэвчлэн байгаа, эдийн засгийн эргэлтэд бүтээлээ оруулж чаддаг эсэхийг судлах хэрэгтэй нь харагдаж байна.

Зураг 13 Шинэ бүтээл, ашигтай загварын патентын ангилал, хувиар



Бүтээгдэхүүний загварыг нийт патентыг ангилалын хувьд авч үзэхэд нийтлэг 13 ангилалд патент хуваагдаж байна. Эдгээрээс ноос, ноолуур, түүний дагалдах хэрэгсэллийн ангилал хамгийн их 966 буюу ангилалыхаа 27,7%-ийг эзэлж байна. Соёл ба боловсролын ангилал 938 (26,9%), сав, баглаа боодол 587 (16,8%), тавилга, гэр ахуйн бараа 442(12,7%), барилга, байгууламжийн ангилал 145(4.1%), хөдөө, аж ахуйн бүтээгдэхүүн, хоол хүнс 127(3,6%), багаж

хэрэгсэл, мэдээллийн технологи ба дуу авиа, тээвэр, зар сурталчилгаа, эрүүл мэнд, гоо сайхан, цахилгаан гэрэлтүүлгийн ангилал 209(6,0%)-ийг тус тус эзэлж байна. Ангилалдаагүй 66(1,8%) байна.

Хүснэгт 11 Бүтээгдэхүүний патентын ангилал, тоо, хувиар

	Ангилал	Патентын ангилалын тоо	Хувь
1	Цахилгаан, гэрэлтүүлэг	16	0,4%
2	Эрүүл мэнд, гоо сайхан	21	0,6%
3	Зар сурталчилгаа	30	0,8%
4	Тээвэр	38	1,09%
5	Мэдээллийн технологи ба дуу авиа	44	1,26%
6	Багаж хэрэгсэл	60	1,72%
7	Ангилалдаагүй	66	1,8%
8	Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, хоол хүнс	127	3,6%
9	Барилга байгууламж	145	4,1%
10	Тавилга, гэр ахуйн бараа	442	12,7%
11	Сав, баглаа боодол	587	16,8%
12	Соёл ба боловсрол	938	26,9%
13	Ноос, ноолуур, түүний дагалдах хэрэгсэл	966	27,7%
	Нийт	3480	100%

Бүтээгдэхүүний загварын патентыг ангилалаар эрэмбэлэн авч үзвэл ноос ноолуур, түүний дагалдах хэрэгслийн ангилал хамгийн их буюу 966(27,7%) байна Дэлхийн хэмжээний ноолуурын нөөцийн 40 хувийг Монгол, 48 хувийг Хятад, 12 хувийг Иран, Афганистан зэрэг улсууд бэлтгэдэг байна. (<https://mofa.gov.mn/exp/blog/11/175>) Нийт уул уурхайн бус салбарын экспорт ерөнхийдөө ноолуурын салбар дээр тогтож байна. (Эх сурвалж: <https://gogo.mn/r/285720?i=>) Эндээс үзэхэд ноос, ноолуур түүний дагалдах хэрэгслийн үйлдвэрлэл Монгол улсын голлох салбар бөгөөд энэ чиглэлийн бүтээгдэхүүний загварын патент авдаг байна.

Зураг 14. Бүтээгдэхүүний загварын патентын ангилал эрэмбэлснээр, хувиар



ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд хамрагдсан 94 хуулийн этгээд, хувь хүмүүсээс судалгаанд 98 асуулга хүчинтэй байна. Эдгээрээс судалгааны үр дүнг нэгтгэн гаргалаа.

Судалгаанд хамрагдагсдын 13 буюу 13,3% нь шинэ бүтээлийн, 36(36.7%) нь ашигтай загварын, 21(21,4%) нь бүтээгдэхүүний загварын, 14(14,3%) нь шинэ бүтээл, ашигтай загварын, 4(4,1%) нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын, 5(5,1%) нь бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын, 5(5,1%) нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчид байна.

Хүснэгт 12 Судалгаанд хамрагдагдсан хуулийн этгээд, хувь хүмүүсийн патентын тоо, хувь


	Патентын тоо	Хувь
Шинэ бүтээл	13	13,3%
Ашигтай загвар	36	36,7%
Бүтээгдэхүүний загвар	21	21,4%
Шинэ бүтээл/ Ашигтай загвар	14	14,3%
Шинэ бүтээл/ Бүтээгдэхүүний загвар	4	4,1%
Бүтээгдэхүүний загвар/ Ашигтай загвар	5	5,1%
Шинэ бүтээл/ Ашигтай загвар/ Бүтээгдэхүүний загвар	5	5,1%
НИЙТ	98	100,0

Хамгаалагдсан патентаа ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг нь хүртэж чадаж байгаа эсэх асуултыг патент эзэмшигчдээс асуун аж үйлдвэрийн өмч тус бүрээр хэрхэн хариулсныг авч үзье.

3.1 ШИНЭ БҮТЭЭЛИЙН ПАТЕНТЫН ХУВЬД


Хамгаалагдсан патентаа ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг нь хүртэж чадаж байгаа эсэх асуултыг патент эзэмшигчдээс асуухад шинэ бүтээлийн патент эзэмшигч 36 хуулийн этгээд, хувь хүмүүсээс 18(50,0%) нь патентаа эдийн засгийн эргэлтэд оруулсан, 12(33,0%) нь үгүй, 6(17,0%) нь хариулаагүй байна.

Зураг 15. Шинэ бүтээлийн патентаа эдийн засгийн эргэлтэд оруулсан эсэх, хувиар



Шинэ бүтээлээ патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж патентын үр ашгийг хүртэж байгаа хуулийн этгээд, хувь хүмүүсийн 4 буюу 22,0% нь шинэ бүтээл, 8 буюу 44,0% нь шинэ бүтээл, ашигтай загварын, 3 буюу 17,0% нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын үлдсэн 3 буюу 17,0% нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын патент эзэмшигчид байна.

Зураг 16. Шинэ бүтээлээ патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж патентын үр ашгийг хүртэж байгаа хуулийн этгээд, хувь хүмүүсийн эзлэх хувь



Эндээс үзэхэд аж үйлдвэрийн өмчийн шинэ бүтээл, ашигтай загварын патенттай эзэмшигч бусдаасаа арай олон тоотойгоор патентаа эдийн засгийн эргэлтэд оруулан үр ашгийг нь хүртсэн гэсэн байна.

Зураг 17. Патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашигаа хүртэж буй патент эзэмшигчид байршлаар



Патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашигаа хүртэж буй патент эзэмшигчдийг байршлаар авч үзэхэд хамгийн их буюу нийслэлийн Баянзүрх дүүрэг 28%, 17% нь Хан-Уул, Сүхбаатар дүүргийн, орон нутгаас Орхон аймгийнх 11%-ийг тус тус байна.

Хамгаалагдсан патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашигаа хүртээгүй патент эзэмшигчдыг авч үзэхэд судалгааны асуулгад хариулсан оролцогчдын шинж бүтээлийн 42%, шинэ бүтээл, ашигтай загвар адил 42%, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвартай, мөн аж үйлдвэрийн 3 патенттай нь адил 8%-ийг эзэлж байна.

Шинэ бүтээлийн патент эзэмшин эдийн засгийн эргэлтэд патентаа оруулан үр ашигаа хүртэж байгаа хуулийн этгээд, хувь хүмүүсээс ямар хэлбэрээр үр ашиг хүртэж байгааг тодруулахад 81,0% нь бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулан, 19,0% нь лиценз болон бусад гэрээгээр ашиглуулдаг гэсэн байна.

Зураг 18. Шинэ бүтээлийн патент эзэмшигчид, патентаа ашигладаг хэлбэрээр, хувиар



Эндээс үзэхэд шинэ бүтээлийн патент эзэмшигчдийн ихэнх буюу 81,0% нь патентаа ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулан патентаа эдийн засгийн эргэлтэд оруулан үр ашигаа хүртэж байна.

Шинэ бүтээлийн патент эзэмшигчдийн эдийн засгийн эргэлтэд патентаа оруулан үр ашигаа хүртэж байгааг хуулийн этгээд, хувь хүн байгаа эсэхийг тодруулахад 1-ээс бусад нь хуулийн этгээд патент эзэмшигч байна.

Шинэ бүтээлийн патент эзэмшигчдийн эдийн засгийн эргэлтэд патентаа оруулан үр ашигаа хүртээгүй патент эзэмшигчдийн ямар шалтгаанаар хамгаалагдсан патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг хүртэж чадахгүй байгааг эрэмбэлэн үзэхэд дараах дарааллаар шалтгааныг дурдсан байна.

Зураг 19. Шинэ бүтээлийн патент эзэмшигчид, патентаа ашиглаж чаддаггүй шалтгаан, хувиар




Эндээс харахад шинэ бүтээлийн патент эзэмшигчдийн патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж чадахгүй байгаа шалтгаан нь ойлголт, туршлага, мэдлэг, мэдээлэл дутмагаас 9(31,0%), хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг хомсоос 8(27,6%), хууль, эрх зүйн орчноос 7(24,1%), бусад шалтгааны улмаас 5(17,2%) тус бүр болдог гэж үзсэн байна.

3.2 АШИГТАЙ ЗАГВАРЫН БҮТЭЭЛИЙН ПАТЕНТЫН ХУВЬД


Хамгаалагдсан патентаа ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг нь хүртэж чадаж байгаа эсэх асуултыг патент эзэмшигчдээс асуухад ашигтай загварын бүтээлийн патент эзэмшигч 60 хуулийн этгээд, хувь хүмүүсийн 17(28,0%) нь патентаа эдийн засгийн эргэлтэд оруулсан, 16(27,0%) нь үгүй, 27(45,0%) нь хариулаагүй байна.

Зураг 20. Ашигтай загварын патентаа эдийн засгийн эргэлтэд оруулсан эсэх, хувиар




Ашигтай загварын бүтээлийн патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж патентын үр ашгийг хүртэж байгаа хуулийн этгээд, хувь хүмүүсийн 36 буюу 66,0% нь ашигтай загвар, 14 буюу 24,0% нь шинэ бүтээл, ашигтай загвар, 5 буюу 8,0% нь бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын, мөн үлдсэн 5 буюу 8,0% нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын патент эзэмшигчид байна.

Зураг 21. Ашигтай загварын патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж патентын үр ашгийг хүртэж байгаа хуулийн этгээд, хувь хүмүүсийн патентын тоо



Эндээс үзэхэд аж үйлдвэрийн өмчийн дан ганц ашигтай загварын патенттай эзэмшигч бусдаасаа арай олон тоотойгоор патентаа эдийн засгийн эргэлтэд оруулан үр ашгийг нь хүртсэн байна.


Зураг 22. Патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашигаа хүртэж буй патент эзэмшигчид байршлаар



Патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашигаа хүртэж буй патент эзэмшигчдийг байршилаар авч үзэхэд хамгийн их буюу нийслэлийн Баянгол дүүрэг 23,0%, Хан-Уул дүүрэг 18,0%, Сонгинохайрхан дүүрэг 17,0%, Сүхбаатар дүүрэг 12,0%, Баянзүрх дүүрэг 6,0%, орон нутгаас Орхон, Сүхбаатар, Өмнөговь аймаг тус тус 6,0% байна.

Ашигтай загварын патент эзэмшигчдийн эдийн засгийн эргэлтэд патентаа оруулан үр ашигаа хүртэж байгааг хуулийн этгээд, хувь хүн байгаа эсэхийг тодруулахад 14 буюу 82,0% нь хуулийн этгээд, 3 буюу 18,0% нь хувь хүн байна.


Зураг 23. Ашигтай загварын эдийн засгийн эргэлтэд патентаа оруулсан патент эзэмшигчид, хуулийн этгээд, хувь хүнээр



Хамгаалагдсан патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашигаа хүртээгүй 16 патент эзэмшигчдийг авч үзэхэд судалгааны асуулгад хариулсан оролцогчдын ашигтай загварын бүтээлийн 50,0%, шинэ бүтээл, ашигтай загвар 31,0%, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын патенттай нь 13,0%, Бүтээгдэхүүний загвар, ашигтай загварийн патенттай нь 6,0%-ийг эзэлж байна.

Ашигтай загварын бүтээлийн патент эзэмшин, эдийн засгийн эргэлтэд патентаа оруулан үр ашигаа хүртэж байгаа хуулийн этгээд, хувь хүмүүсээс ямар хэлбэрээр үр ашиг хүртэж байгааг тодруулахад 81,0% нь бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулан, 13,0 хувь нь лиценз болон бусад гэрээгээр ашиглуулан, мөн 6,0% нь бусад буюу патентаа худалдах гэсэн байна.

Зураг 24. Ашигтай загварын патент эзэмшигчид, патентаа ашиглаж байгаа хэлбэр, хувиар



Эндээс үзэхэд ашигтай загварын патент эзэмшигчдийн ихэнх буюу 81,0% нь патентаа ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулан патентаа эдийн засгийн эргэлтэд оруулан үр ашигаа хүртэж байна.

Ашигтай загварын патент эзэмшигчдийн эдийн засгийн эргэлтэд патентаа оруулан үр ашигаа хүртээгүй патент эзэмшигчдийн ямар шалтгаанаар хамгаалагдсан патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг хүртэж чадахгүй байгааг эрэмбэлэн үзэхэд хууль, эрх зүйн орчиноос 17 буюу 35,4%, бусад шалтгаанаас 15 буюу 31,2%, хөрөнгө, санхүүгийн дэмжлэг хомсоос 9 буюу 18,7%, ойлголт, туршлага, мэдлэг, мэдээлэл дутмагаас 7 буюу 14,5% болж патентаа ашиглаж чаддаггүй гэсэн байна


Зураг 25. Ашигтай загварын патент эзэмшигчид, патентаа ашиглаж чаддаггүй шалтгаан, хувиар



3.3 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ПАТЕНТЫН ХУВЬД


Хамгаалагдсан патентаа ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг нь хүртэж чадаж байгаа эсэх асуултыг бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчдээс асуухад бүтээгдэхүүний загварын патент эзэмшигч 36 хуулийн этгээд, хувь хүмүүсээс 24(67,0%) нь патентаа эдийн засгийн эргэлтэд оруулсан, 6(16,6%) нь оруулаагүй, 6(17,0%) нь хариулаагүй байна.

Зураг 26. Бүтээгдэхүүний загварын патентаа эдийн засгийн эргэлтэд оруулсан эсэх, хувиар




Бүтээгдэхүүний загварын патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж патентын үр ашгийг хүртэж байгаа хуулийн этгээд, хувь хүмүүсийн 16 буюу 66,7% нь бүтээгдэхүүний загвар, 3 буюу 12,5% нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын, 3 буюу 12,5% нь бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын үлдсэн 2 буюу 8,3% нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын патент эзэмшигчид байна.

Зураг 27. Бүтээгдэхүүний загварын патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж патентын үр ашгийг хүртэж байгаа хуулийн этгээд, хувь хүмүүсийн патентын эзлэх хувь



Эндээс үзэхэд бүтээгдэхүүний загварын эзэмшигчдын 66,6% нь патентаа эдийн засгийн эргэлтэд оруулан үр ашгийг нь хүртдэг байна.


Зураг 28. Патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашигаа хүртэж буй патент эзэмшигчид байршлаар



Патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашигаа хүртэж буй патент эзэмшигчдийг байршилаар нь авч үзэхэд хамгийн их буюу нийслэлийн Баянзүрх дүүрэг 25%, Сонгинохайрхан дүүрэг 17%, Сүхбаатар дүүрэг 12%, Хан-Уул дүүрэг 25%, Чингэлтэй дүүрэг 4%, Баянгол дүүрэг 17%-ийг тус тус байна.

Бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчдийн эдийн засгийн эргэлтэд патентаа оруулан үр ашигаа хүртэж байгааг хуулийн этгээд, хувь хүн байгаа эсэхийг тодруулахад 22 буюу 91,6% нь хуулийн этгээд, 2 буюу 8,3% нь хувь хүн байна.

Зураг 29. Бүтээгдэхүүний загварын эдийн засгийн эргэлтэд патентаа оруулсан патент эзэмшигчид, хувь хүн, хуулийн этгээдээр



Хамгаалагдсан патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашигаа хүртээгүй патент эзэмшигчдийг авч үзэхэд судалгааны асуулгад хариулсан оролцогчдын 66,6% нь бүтээгдэхүүний загварын, 33,3% нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварынх байна.

Бүтээгдэхүүний загварын патент эзэмшин эдийн засгийн эргэлтэд патентаа оруулан үр ашигаа хүртэж байгаа хуулийн этгээд, хувь хүмүүсээс ямар хэлбэрээр үр ашиг хүртэж байгааг тодруулахад 82,0% нь бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулан, 14,0 хувь нь лиценз болон бусад гэрээгээр ашиглуулдаг, 3,6% нь патентаа худалдах гэх мэтээр ашигладаг гэсэн байна.

Зураг 30. Шинэ бүтээлийн патент эзэмшигчид, патентаа ашигладаг хэлбэрээр, хувиар



Эндээс үзэхэд бүтээгдэхүүний загварын патентаа ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг нь хүртэгсдийн ихэнх буюу 82,1% нь патентаа ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулан патентаа эдийн засгийн эргэлтэд оруулан үр ашигаа хүртэж байна.

Бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчдийн эдийн засгийн эргэлтэд патентаа оруулан үр ашигаа хүртэж чадаагүй хувь хүн, хуулийн этгээдээс ямар шалтгаанаар хамгаалагдсан патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг хүртэж чадахгүй байгааг тодруулан шалтгааныг эрэмбэлэн авч үзлээ.

Зураг 31. Бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчид, патентаа ашиглаж чаддаггүй шалтгаан, хувиар



Эндээс харахад бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчдийн патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж чадахгүй байгаа шалтгааны 31,2% нь ойлголт, туршлага, мэдлэг, мэдээлэл дутмагаас, 37,5% нь хууль, эрх зүйн орчноос, 31,2% нь хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг хомсоос тус бүр болдог гэж үзсэн байна.

3.4 ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ

Судалгаанд хамрагдагсдаас хөрөнгийн үнэлгээ хийлгэдэг эсэхийг асуухад 9 патент эзэмшигчид хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн гэсэн байна. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдагсдын 9,1% нь хөрөнгийн үнэлгээг хийлгэсэн байна.

Хүснэгт 13. Хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн патент эзэмшигчид, тоо, хувиар

Патент эзэмшигч	Үнэлүүлсэн патентын тоо	Хувь
Шинэ бүтээл	1	11,1%
Ашигтай загвар	2	22,2%
Бүтээгдэхүүний загвар	1	11,1%
Шинэ бүтээл/ Ашигтай загвар	4	44,4%
Шинэ бүтээл/ Ашигтай загвар/ Бүтээгдэхүүний загвар	1	11,1%
Нийт	9	100%

Хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн патент эзэмшигчдийн 44,4% нь шинэ бүтээл, ашигтай загварын, 22,2% нь ашигтай загварын, 11,1% нь бүтээгдэхүүний загварын, 11,1% нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчид байна.

Эдгээрийн 7 нь буюу 77,7% нь хуулийн этгээд, 2 буюу 22,2% нь хувь хүн байна.

Үнэлүүлсэн патентын тоог авч үзэхэд 1 бүтээлээ үнэлүүлсэн 7, 4 бүтээлээ үнэлүүлсэн 1, 5 бүтээлээ үнэлүүлсэн 1 патент эзэмшигчид байна.

Үнэлүүлсэн үнийн дүнг тодруулахад 200 мянгаас 1,2 тэрбум төгрөгөөр патентаа үнэлүүлжээ. Хамгийн өндөр үнээр үнэлүүлсэн патент эзэмшигчийг тодруулахад шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент эзэмшдэг Чиглэл ХХК байна.

Хүснэгт 14. Үнэлүүлсэн үнийн дүн, бүтээлийн тоо, үнэ төгрөгөөр

Эзэмшдэг патент	Үнэлүүлсэн үнэ, төгрөгөөр	Үнэлүүлсэн бүтээлийн тоо
Шинэ бүтээл	12,000,000,000₮	1
Ашигтай загвар	600,000₮	1
Бүтээгдэхүүний загвар	200,000₮	1
Шинэ бүтээл/ Ашигтай загвар	417,000,000₮	2

Шинэ бүтээлийн патентыг үнэлсэн үнэлгээний үнийн дүн бусад патент эзэмшигчдийхээс өндрөөр үнэлэгдсэн байна.

3.5 ОЮУНЫ ӨМЧИЙН БҮТЭЭЛИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ САНАЛ, ХҮСЭЛТ

Оюуны өмчийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулахтай холбоотой санал, хүсэлт байгаа эсэхийг судалгаанд хамрагдагсдаас авч нэгтгэлээ. Судалгаанд хамрагдагсдын 61,8% нь ямар нэгэн санал, сэтгэгдлээ бичиж илэрхийлсэн байна. Үлдсэн хувь нь ямар нэгэн санал байхгүй гэсэн байна.

Судалгаанд хамрагдагсад дараах байдлаар санал, сэтгэгдлээ бичгээр илэрхийлсэн байна.

Хууль, эрх зүй, оюуны өмчийн бодлогын талаар

- Оюуны өмчийн бүтээлээ бүртгүүлсэн ч хамгаалуулж чадахгүй байна.
- Эзэмшигч нь байгууллага, зохиогч нь хувь хүн байгаа тохиолдолд зохиогч үр дүнг нь тэр бүр хүртдэггүй.
- Өнөөгийн хууль эрх зүйн хүрээнд төсвийн хөрөнгөөр бий болгосон оюуны өмчийн эзэмшигч нь санхүүжүүлэгч буюу төр, судлаач зөвхөн зохиогч гэдэг утгаар эдийн засгийн эргэлтэд оруулах ямар нэг алхам хийгддэггүй.
- Хууль эрх зүйн үүднээс оюуны өмчийн баталгаажилт авсан боловч адил бүтээгдэхүүн зах зээлд нэвтэрснээс ашиг орлого муудаж, дахин оюуны өмчийн баталгаажилтын ач холбогдолд эргэлзэх болсон, төр болон хариуцсан оюуны өмчийн газар арга хэмжээ авч ажилладаггүй, баталгаажилт авсан байгууллага, хүнийг дэмждэггүй, харин томоохон аж ахуйн нэгжүүдтэй илүү ойр дэмжиж ажилладаг, жижиг аж ахуй нэгж болон хувь хүмүүсээ тоодоггүй, хэрэгждэггүй.
- Монгол хүний хийсэн зүйлд итгэдэггүй, дэмждэггүй
- Аж үйлдвэрийн инновацийн тухай ойлголт, мэдлэг, мэдээлэл дутмаг, Аж үйлдвэрийн өмчид тулгуурлан инновацийн төсөл хэрэгжүүлэх үйл явцын хууль, эрх зүйн орчны зохицуулалт тодорхой бус байна.
- Тэндэрт оролцож ажил хийж үзсэн. Элдэв бичиг цаас, тодорхойлолт, стандарт гээд наян юм болдог.
- Оюуны өмчийн бүтээлээ туршилт судалгаагаа тогтмол хийсээр улам сайжруулж чадсан ч дахиад хулгайд алдахааас айгаад том хэмжээний төсөлд хэрэглэх шийдвэр гаргаад хав дарсан.
- Оюуны өмчийн бүтээл бүтээгчид Оюуны өмчөө бүртгүүлэх, хамгаалуулах үйлчилгээний талаарх мэдлэг сул байдаг.
- Төсөл болон тендер шалгаруулалтад оюуны өмчийн бүтээлийн үнэлэмж тун тааруу байдаг. Мөн оюуны өмчийн хулгайд оногдуулах торгууль ногдуулах хариуцлага сул байна.
- Хууль эрх зүйн орчинг зөв бүрдүүлвэл оюуны өмчөө эдийн засгийн эргэлтэнд оруулж болно.
- Хууль эрх зүйн орчинг чангатгаж, оюуны өмч эзэмшиж буй эзэмшигчдэд олон боломжуудыг гаргаж өгөх хэрэгтэй.
- Хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, сайжруулах хэрэгтэй.
- Салбар тус бүрт чиглэсэн оюуны өмчийн бүтээлийг олон нийтэд таниулах, нэн ялангуяа үндэсний үйлдвэрлэгч байгууллагын оюуны өмчийн бүтээлд зохих арга хэмжээг авч, засгийн газрын бодлогоор дэмжиж өгөх, туслалцаа үзүүлэх, хөрөнгө оруулалт хийх гэх мэтээр байгуулагаруу чиглэсэн үр өгөөжтэй дэмжлэг үзүүлэх.
- Дотоодын үйлдвэр эрхлэгч аж ахуй нэгж, хувь хүмүүс рүү чиглэсэн бодлого хэрэгжүүлэх

Төрийн нэгдсэн бодлого, хариуцсан яамдын үйл ажиллагааны талаар

- Мэргэжлийн яамд илтгэл, тайлан гаргахаас хэтэрдэггүй.
- Төр засгийн хөшүүн хойрго байдал тэнд ажиллагсад нь өөрт ашиггүй бол үл ойшоох байдлыг өөрчлөх шаардлагатай.
- Оюуны өмчийн патентыг барьцаанд тавьж болно гэсэн боловч банкин дээр татгалздаг.
- Одоогийн цар тахалтай холбогдон үйл ажиллагаагаа зогссон.

Оюуны өмчийн бүтээлээ хэрхэн эдийн засгийн эргэлтэнд оруулах талаар

- Бүтээлээ хэрхэн эдийн засгийн эргэлтэнд хэрхэн оруулахаа мэдэхгүй байна.
- Өөрөө л үйддвэрлээд борлуулахгүй бол эдийн засгийн эргэлтэнд орох боломжгүй
- Оюуны өмчийг нэн даруй эдийн засгийн эргэлтэнд оруулах ач холбогдлыг дараагийн шатны байгууллага ойлгохгүй, дахин маш их цэнзур тавьж удаашруулж байна.
- Инноваци шинэ бүтээгдэхүүний уралдаан тогтмол зарлаж, эхний байруудыг шаркууд эсвэл төрөөс шууд санхүүжүүлж, бизнесийн багийг бүрдүүлэх механикм бүрдүүлж хэрэгжүүлэх, ялангуяа олон улсад патент авахад нь санхүүжүүлэх, эргэлтэнд оруулах, ингэснээр оюуны бүтээлд долларын хөрөнгө оруулалт хийх боломжтой болно. Зохион бүтээгчид шургуу ажиллана.
- Хүүхэд багачуудад инноваци шинэ бүтээл хөгжлийн гол түлхүүр гэдгийг сурталчилан таниулах хэрэгтэй.

Бүтээгдэхүүн хуурамчаар үйлдвэрлэгдэж буй талаар

- Бүтээгдэхүүнээ цөөн тоогоор санхүүгийн боломждоо тааруулан үйлдвэрлэж борлуулсан боловч дараа жил нь урд хөршөөс манай бүтээгдэхүүнийг үйлдвэрлээд оруулж ирсэн байсан.
- Оюуны өмчөө хамгаалж чаддаггүй, бидний бүтээлийг наймаачид захиалаад Эрээн дээр дууриалгаж хийдэг. Өвөрмонголчууд бас дуурайж хийгээд Эрээн дээр бөөнддөг.
- Миний шинэ бүтээл Хятадад үйлдвэрлэгдэн Монголын зах зээлд борлуулагдаж байна.
- Шинэ бүтээгдэхүүний шинж чанар, загварыг дуурайдаг байдлыг сайжруулмаар байна. Мөн паттенттай байлаа гээд хуулбарлаж байгаа газраас эрхийг нь хэрхэн авахаа мэдэхгүй байна. Хаана хэрхэн хандахаа мэдэхгүй байна.
- Оюуны өмчтэй бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах явцад бусад хуулан дууриах асуудал гарч байна. Энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ?
- Манай үйлдвэрлэн борлуулдаг хивснийг БНХАУ-д дууриамалаар хийлгэн Нарантуул захад их хэмжээгээр борлуулдаг тул БНХАУ-ын оюуны өмчийн газартай хамтран ажиллавал маш сайн байна.

Оюуны өмчийн бүтээлийн үнэлгээний талаар

Санал өгсөн судалгаанд хамрагдагсдын 60 гаруй хувь нь үнэлгээ хийх шаардлагатай гэж үзсэн байгаа бөгөөд үнэлгээтэй холбоотой дараах сэтгэгдэл бичсэн байна.

- Оюуны өмчийн үнэлгээчин бэлтгэгдээгүй /эхлээд оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, дараа нь хөрөнгийн үнэлгээчин болох шаардлагыг хангасан хүн ОЮУНЫ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭЧИН байх нь зохистой/

- Эзэмшигч нь байгууллага, зохиогч нь хувь хүн байгаа тохиолдолд шинэ бүтээлийг үнэлж 1 удаа дорвитой урамшуулах эсвэл үйлдвэрлэн борлуулах бүрт хувь өгдөг байх
- Үнэлгээжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.
- Оюуны өмчийн бүтээлээ үнэлүүлэхэд хаана хандах вэ? зөвлөгөө мэдээлэл хаанаас авдаг байх вэ?
- Хаана үнэлүүлэх нь тодорхой бус, эсвэл бид мэддэггүй.
- Үнэлүүлээд ямар өгөөжтэй болох нь тодорхойгүй, бид мэдлэггүй.
- Оюуны өмчийн бүтээгдэхүүний загвараа хаана үнэлгээ хийлгэх вэ?
- Үнэлгээ хийх эрх зүйн орчин тодорхойгүйгээс хийгдсэн үнэлгээнд үнэ цэнийн бууралт хийгддэг, хэрхэн үнэлэх, хэрхэн бүртгэх талаар нарийвчилсан дүрэм журам гаргах
- Мэргэшсэн үнэлгээ хийдэг газартай болох

Оюуны өмчийн газрын үйл ажиллагааны талаар

- Оюуны өмч бүртгэл болон давхардал үүссэнтэй холбоотой маргааныг хурдан шийдвэрлэх шаардлагатай байна.
- Оюуны Өмчийн газар патентуудыг эдийн засгийн эргэлтэнд оруулах ажлыг хийж гүйцэтгэмээр байна. Жинхэнэ оюуны өмчийн үнэлгээ өндөр байх ёстой.
- Оюуны өмчид бүртгүүлсэн аливаа зүйлийн зохиогчийн эрхийн хамгаалалт бүрэн хэрэгжин хамгаалагддаггүй.
- Хүний хийсэн юмыг даган дуурайж хийгээд патент авч байгаа хүмүүсийг жинхэнэ анхдагч нарыг ялгаж хийсэн бүтээлийг хүн томилон нүдээр үздэг баймаар байна.
- Оюуны өмчийн бүтээлийн өгөөж, үр ашиг, цар хүрээг нь анхаарч Оюуны өмчийн газар баталж бүртгэсэн оюуны өмчүүдээ, эзэмшигчдийнхээ эрх ашгийг хамгаалдаг байвал зүгээр.
- Оюуны өмчийн шинэ хуулийн дагалдах журмуудыг гаргах, олон нийтэд хүргэх

Сургалт, сурталчилгаа, мэдээлэлтэй холбоотой үйл ажиллагааны талаар

Сургалт, сурталчилгаа, мэдээлэлтэй холбоотой хэдэн сэтгэгдэл байна.

- Патент эзэмшигчдийг сургалтанд хамруулдаг болох, Оюуны өмчийн талаарх ойлголтыг өгдөг байх
- Оюуны өмчийн талаар мэдээ, мэдээллийг сайжруулах, сургалтад байнга хамрагддаг байх
- Оюуны өмчийн бүтээлээ яаж эргэлтэнд оруулах талаар сургалт хийж мэдээлэл өгөх

Бусад санал, зөвлөмж

- Бүтээгдэхүүний загвар алдагдсан тухай мэдээллийн дагуу хяналтын алба холбогдох мэргэжлийн байгууллагууд санаачлагатай шуурхай ажиллах
- Салбарын яам патентыг судлаж үйлдвэрлэлд нэвтрүүлэх, ашиглах талаар тодорхой бодлого боловсруулж хөрөнгө төсөвлөж байх хэрэгтэй байна
- Шинэ технологи загвар бүтээхэд Монгол шаардлагатай бараа материалууд хомсдмол байдаг, ихэнхдээ гадаадаас тусгай захиалгаар хийлгэж туршиж үзэж зардал нэмэгддэг. Хөрөнгө оруулалтын дэмжлэгийг сайжруулах хэрэгтэй байдаг.
- Хөрөнгө оруулагч, үйлдвэрийн газрын удирдлагуудад сурталчлах ойлголтын сурталчилгаа хийх, мэдээлэл түгээх шаардлагатай байна.
- Патентыг олон улсад бүртгүүлэх хураамжид төрөөс дэмжлэг үзүүлдэг болох хэрэгтэй.
- Олон улсын хамгаалалт дээр маш сайн чиглэл, дэмжлэг өгмөөр байна.

- Оюуны өмчийн татвар авдагийг багасгах, татварын бодлогоор патент эзэмшигчдийг дэмжих хэрэгтэй.
- Жижиг дунд үйлдвэрийн зээлд хамруулах, хуульд оруулах хэрэгтэй.
- Оюуны өмч зөрчсөн бол эрүүгийн хэрэг үүсгэх заалт хэрэгждэг үгүйг бас мэдэхгүй. Уул нь жирийн хулгайгаас илүү хатуу шийтгэх шаардлагатай байдаг.

Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент эзэмшигч 2 иргэний сэтгэгдлийг орууллаа.

Дэргэр Агьт ХХК, Ж.Дамдинсүрэнгийн сэтгэгдлээс

Миний бие сүүлийн 3-н жилд нийт дүн нь 573,0 сая төгрөгний оюуны өмчийн баталгаатай эм бэлдмэлээ үйлдвэрлэж эдийн засгийн эргэлтэнд орсоор ажиллаж байна. Малын эм бэлдмэлүүдийг манай Дэргэр-Агьт ХХК-ний эрдэмтэд зохион бүтээж, баталгаажуулан оюуны өмчийн бүртгэлд орж орон даяар үйлдвэрлэлд нэвтрэн монгол улсын мал эмнэлгийн малын эмийн бүртгэлд бүртгүүлэн 1995 оноос эхлэн малын эмчилгээнд хэрэглэсээр байна. Дээрх эм бэлдмэлүүдийг Зохиогч Монгол Улсын Гавьяат малын эмч, доктор (Ph.D), дэд профессор, МУ-ын Зөвлөх малын эмч Ж.Дамдинсүрэн нь 2005 онд Дэргэр-Агьт ХХК-ыг үүсгэн байгуулж малын эмийн жижиг үйлдвэртээ үйлдвэрлэн улсынхаа хэрэгцээг хот, аймаг, сумын мал эмнэлгийн байгууллага, малын эмч нартай гэрээ байгуулан хангаж эдийн засгийн эргэлтэнд оруулсаар байна. Манай компани нь Оюуны өмчийн газраар баталгаажсан эдгээр бүтээгдэхүүнээс өөр эм үйлдвэрлэхгүй зөвхөн зохион бүтээсэн бүтээлээрээ үйлдвэрлэлийг малын эмийн фармакопейн хорооны баталгаажилтын дугаар, зураасан код, улсын бүртгэлийн дугаар, малын эмийн сорилт баталгаажилтын шалгалтын дүгнэлтээр баталгаажин зах зээлд нийлүүлэгдэн эдийн засгийн эргэлтэнд орсоор байна. Манай үйлдвэртэй адил төстэй баталгаатай үйлдвэр манай улсад байхгүй. Мөн тус үйлдвэр нь зөвхөн зохиогчийн баталгаат эм, бэлдмэлээ үйлдвэрлэхдээ инновацийн төсөл, хөтөлбөрт болон гарааны компаниар дамжиж эхлээгүй, бие даан байгуулан ажилласаар ирсэн билээ. Оюуны өмчийн баталгаат эм, бэлдмэлийг үйлдвэрлэж байгаа манай компани нь эдгээр эм, бэлдмэлээрээ 2010 оноос эхлэн НҮБ болон Олон Улсын хамтын ажиллагааны тусламжийн үйл ажиллагаанд оролцож зудад нэрвэгдсэн, аймгуудын малчин ардуудын ядарч доройтсон малд хүргээдэг эмчилгээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч амжилтыг үзүүлсээр байна. Ийнхүү компаний эрдэмтэдийн зохион бүтээж үйлдвэрлэлд нэвтрүүлэн үйлдвэрлэж байгаа эдгээр эм, бэлдмэлүүдээ зах зээлд бөөний хямд үнээр нийлүүлэн хэрэглэгчтэйгээ эдийн засгийн эргэлтэнд оруулан үр дүнтэй ажиллаж байна.

Хамгийн олон патент эзэмшигч иргэн А.Чойжамцын сэтгэгдлээс

Миний бүтээлүүд ихэвчлэн ХАА, Газар тариаланд зориулагдсан хөрсний үржил шимийг сайжруулах, нөхөн сэргээх, ургамал, таримлын ургац нэмэгдүүлж чанарыг сайжруулах, байгалийн хадлан, бэлчээрийг сайжруулах, өвсний ургацыг нэмэгдүүлэхэд зориулагдсан органик бордоо-компост, эрдэс нийлмэл бордоо түүнчлэн хуурай ба шингэн төлөв байдлаар үйлдвэрлэх онцлогтой юм. Мэргэжлийн яамд (ХХААХҮЯ, БОАЖЯ зэрэг) онцгой анхаарал тавих ёстой атал огт хэрэгсдэггүй. Зүгээр л хөрс доройтлоо, тэдэн хувиар цөлжилт явагдлаа гэж баахан тоо баримт дурдаж, илтгэл, тайлан гаргахаас хэтэрдэггүй. Ийм байдлыг арилгах, сайжруулахад яах ёстой юм гэдэг талаар шинжлэх ухаанчаар хандмаар байна. Бидний бүтээлийн бордоонууд ШУТСангийн инновацийн төсөл гүйцэтгэж, ОӨГ-аар баталгаажиж гаргасан бүтээлүүд, Гэтэл төр, засаг инноваци нутагшуулна, эрдэмтдийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэнд оруулна гэж их ярих боловч хэрэгжилтийн тал дээр бүтээлч ажилладаггүй. Бид баримт болсон нэг хуудас цаас л хадгаладаг хүмүүс болж хоцордог. "Монгол экзолгийн бордоо" компани, үйлдвэр нь бага хэмжээгээр бордоо үйлдвэрлэж байгаа ч ашигтай ажиллаж чаддаггүй учир бүтээлийг эзэмшигч нарт ашиг олддоггүй. Ялангуяа газар тариалангийн компаниуд бордоог авч хэрэглээд төлбөр өгч чадахгүй байх. Тиймээс аж ахуй хоорондын он дамжсан өр, авлага ихэсдэг. Тиймээс зохиогчид юм хүртэж чаддаггүй, зүгээр л ашиглуулаад байж байдаг. Ер нь Монгол улс оюуны өмч, патент, бүтээлийг бусад хөгжилтэй орнуудын адилаар, зах зээлийн зарчимаар ашиглах, үнэлэх мэдлэг, боловсролын хувьд ойлголт дээрээ ч, доороо ч хаана нь ч суугаагүй гэж үзэж болно. Хууль эрх зүйн орчноо одоо ч төгс бүрдүүлээгүй, дөнгөж л эхлэлийн байдалтай, хууль гаргаж, одоо л ярьж эхлэж байгаа. Хөгжилтэй орны эрдэмтэд, санаачлагчид нэг хуудас цаасаар (патент) амьдрал нь баталгаажиж, хангалуун ажиллаж, амьдарч байдгийг гадаад харилцагч нөхөдтэй ярилцаад мэдээлэл авч л байлаа. Ер нь энэ асуудалд мэргэжлийн яам л онцгой анхаарах ёстой. Сайд дарга нар энэ талаар мэдлэг маш муу, тиймээс засаг, төр тэд нартайгаа шаардлага таьж ажиллах ёстой. Бид тэр салбарийн хөгжилд л зориулж ажилласан гэдгийг ойлгох хэрэгтэй юм.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

4.1 ДҮГНЭЛТ

Оюуны өмчийн газар нь Үндсэн хууль болон Монгол Улсын бодлогын баримт бичгүүд, Олон улсын нэгдэн орсон 16 гэрээ, хэлэлцээр, конвенцод тусгагдсан оюуны өмчийг хамгаалах, урамшуулах бодлогыг хэрэгжүүлэхээр Патентын тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулиудыг хэрэгжүүлж патент, гэрчилгээг бүртгэж, эрхийн хамгаалалтын хийж байна. Мөн дээрх хуулиудаас гадна Инновацийн тухай хууль, Технологи дамжуулах тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Оюуны өмчийн газар нь 1990-1996 оны хооронд Үндэсний хөгжлийн газрын харъяа Патент, барааны тэмдгийн газар, 1996-2016 он хүртэл Хууль зүй, Дотоод хэргийн яам, Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Оюуны өмчийн газар гэсэн статустайгаа үйл ажиллагаа явуулж ирсэн. Мөн 2016 онд Хууль зүй, дотоод хэргийн яамны харъяа Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газар нэртэйгээр Улсын бүртгэлийн байгууллагатай нэгтгэн зохион байгуулагдан үйл ажиллагаа явуулж байсныг Засгийн газрын “Засгийн газрын зарим агентлагийн талаар авах арга хэмжээний тухай” 175 дугаар тогтоолын дагуу Оюуны өмчийн газрыг дахин байгуулсан.

Патентын тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд 1963 оноос өнөөг хүртэл цаасан болон цахимаар мэдүүлэг хүлээн авч шинэ бүтээлээр 6783, ашигтай загварын 4555, бүтээгдэхүүний загварын 4253, дугаар олгогдон материал (2021 оны 10 сарын 4-ны байдлаар) хүлээн авсан байна. Цаасаар авч байсан үеийн мэдээллийг цахим мэдээллийн санд нэгтгэн хийх ажлыг амжилттай зохион байгуулж байна. Мөн Зөрчил шалган шийдвэрлэх хуулиар харъяалуулсан Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтуудыг хянаж хуульд заасан хариуцлага, арга хэмжээг авч ажиллаж байна.

Байгууллагын 2021 оны төлөвлөгөөт ажил болох Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг эхлүүлэн патент эзэмшигчдыг хамруулан Патент эзэмшигчдээс хуулийн этгээд, хувь хүмүүсийн төлөөллийг хамруулан Оюуны өмчийн бүтээл эдийн засгийн эргэлтэд орж үр ашиг хүртэж байгаа эсэхэд судалгаа хийж, эдийн засгийн эргэлтэд оруулахад тулгарч буй асуудлуудыг тодруулан, шийдвэрлэх боломжийг судлан бодлого боловсруулагчдад санал зөвлөмж хүргүүлэх, алдаршуулан сурталчилах, туршлага солилцох, цуглуулах, патент эзэмшигчдийн саналыг цуглуулах зорилгоор энэхүү судалгааны ажлыг эхлүүлсэн. Уг ажил жил бүр давталттайгаар хийгдэх ба цаашид улам сайжирч, оюуны өмчийн бүтээл эдийн засгийн эргэлтэд ороход чухал хувь нэмэр үзүүлж, байгууллагын хэтийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход чухал хувь нэмрээ оруулна.

Оюуны өмчийн газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.7 дэх хэсгийг үндэслэн эдийн засгийн эргэлтэд орж буй шинэ бүтээл, түүний эзэмшигчийн судалгааг гаргаж, мэдээллийн сан үүсгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Оюуны өмчийн газрын даргын 2021 оны 09 сарын 28-ны өдрийн тушаалаар ажлын хэсгийн ахлагчаар С.Ганзориг (Захиргаа удирдлагын хэлтсийн дарга), гишүүдээр Б.Оргилмаа (Шинэ бүтээл, ашигтай загварын ахлах шинжээч), Б.Номиндарь (Бүтээгдэхүүний загварын шинжээч), Ц.Галцогт (Шинэ бүтээл, ашигтай загварын шинжээч), нарийн бичгээр Ц.Эрдэнэцэцэг (Шинэ бүтээл, ашигтай загварын шинжээч) нарийн бүрэлдэхүүнтэй баг байгуулагдсан.

Уг ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд дараах ажлуудыг хийхээр төлөвлөн 2021 оны 10 сарын 4-нээс 31-ны хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Оюуны өмчийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулж, ашиг шимийг патент эзэмшигчид хүртэж байгаа эсэх, патентаа бүртгүүлснээр өөрийн эдийн засгийн чадавхиа нэмэгдүүлж байгааг мэдэж, судлах, өнөөгийн байдлыг судлах, мөн “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын 2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-ний 5 дугаар зүйлийн “5.1 Оюуны өмчийн эдийн засгийн эргэлтэд оруулах хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах ажлын бэлтгэлийг хангах чиглэлийн хүрээнд энэхүү Оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулж буй хувь хүн, хуулийн этгээдийн судалгааг хийх зайлшгүй хэрэгцээ шаардлага бий болсон. Мөн Оюуны өмчийн тухай хуулийн 20, 22 дугаар зүйлд Оюуны өмчийн үнэлгээний талаар заасан байгаа. Эдгээр хэрэгцээ, шаардлагын үндсэн дээр дараах зорилго, зорилт дэвшүүлэн судалгаа хийсэн. Ингэхдээ 2021 оны 9 сарын 26-ны өдрөөс өмнө хэрэгжиж байсан патентийн тухай хуулийн дагуу мэдээллээ нэгтгэсэн болно.

Патент эзэмшигчдээс хувь хүн, хуулийн этгээдийн төлөөллийг хамруулан Оюуны өмчийн бүтээл эдийн засгийн эргэлтэд орж үр ашиг хүртэж байгаа эсэхэд судалгаа хийж, эдийн засгийн эргэлтэд оруулахад тулгарч буй асуудлуудыг тодруулан, шийдвэрлэх боломжийг судлан бодлого боловсруулагчдад санал зөвлөмж хүргүүлэх, алдаршуулан сурталчилах, туршлага солилцох зорилготой байлаа.

Судалгааны зорилгыг хангах үүднээс 9 зорилтуудыг дэвшүүлэн биелүүллээ. Энэхүү судалгааг зохион байгуулахдаа нийт патент эзэмшигчдээс шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар тус бүрээр бүлэг үүсгэн сонгож статистик тоон мэдээлэл болон холбогдох бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийх арга зүйг баримтлан ажилласан. Ингэхдээ асуулга, баримт бичиг, мэдээлийн сангийн судалгааны аргуудыг ашиглан мэдээлэл цуглуулж, нэгтгэн дүгнэлээ. Тус арга зүйгээр одоогийн бэлэн байгаа тоон болон баримт бичгийн мэдээллийг нэгтгэн, тэдгээрийг харьцуулан судалж, дүн шинжилгээ хийсэн. Мөн Оюуны өмчийн бүтээлээ эдийн засгийн эргэлтэд оруулахтай холбоотой санал хүсэлтийг цуглуулан нээлттэй асуулттай асуумж боловсруулж, мэдээллийг нэгтгэн дүгнэлээ.

Тоон судалгаанаас гадна чанарын судалгааны арга хэрэглэсэн. Энэ арга нь судлаачдад асуудлыг гүн, нарийн олон талаас нь судлах боломжийг олгохоос гадна судалгааны шинэ санааг бий болгох нөөцийг бүрдүүлдэг. Чанарын судалгаа нь нээлттэй асуулттай ба энэ нь судалгаанд оролцогчдын санал бодол, сэтгэгдэл, туршлагын арвин мэдээллээр хариулагдах боломжтой байдаг учир асуулгын сэдвийн хүрээнд ганцаарчилсан ярилцлага, чөлөөт ярилцлага хийж патент эзэмшигчдийн үгийг сонсох, алдаршуулан сурталчилах, туршлага солилцох зорилгоо биелүүлсэн.

Судалгааны асуулга нь нийт 6 асуултаас бүрдсэн бөгөөд патент эзэмшигчийн мэдээлэл, эдийн засгийн эргэлтэд оруулж үр ашигаа хүртэж чадаж байгаа болон чадахгүй байгаа эсэх, хөрөнгийн үнэлгээ хийсэн эсэхийг асуусан үндсэн асуулттай. Ингэхдээ эзэмшиж буй патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж үр ашигаа хүртэхдээ ямар хэлбэрээр, хүртээгүй байгаа бол ямар шалтгаанаар хүртэхгүй байгааг илрүүлэх зорилгоор асуусан асуулгатай. Мөн санал, хүсэлтийг нээлттэй асуусан асуумжтай.

Асуулгыг гүүгл форм ашиглан майл хаягуудыг өөрсдөөс нь тодруулан мэйлээр явуулж, мэдээллийг цуглуулсан. Асуулга нь цөөн асуулттай сонгох болон нээлттэй хэлбэртэй учир оролцогчдоос цаг хугацаа их зарцуулахыг шаардаагүй байсан. Оролцогчдоос асуулга авах хэлбэрээр гомдол санал ирээгүй болно. Зарим олон патент эзэмшигчидтэй газрууд давхар майл хаяг өгсөн. Тийт 105 мэйлээр асуулгын линк илгээгдсэн.

Судалгаанд хүчинтэй байгаа шинэ бүтээлийн 129, ашигтай загварын 601, бүтээгдэхүүний загварын 435 патент эзэмшигчдээс олон тоотой патент эзэмшигч сонгох эхний шалгуурыг тавьж шинэ бүтээлийн патент эзэмшигч 50, ашигтай загварын патент эзэмшигч 20, бүтээгдэхүүний загварын патент эзэмшигч 30 хувь хүн, хуулийн этгээдийг сонгосон.

Ингэхдээ шинэ бүтээл 20 жил, ашигтай загвар 7 жил, бүтээгдэхүүний загвар 10 жилийн хугацаанд эрх нь хүчинтэй, эрх нь хамгаалагдсан патент эзэмшигчдийг хамруулсан. (Хуучин патентын хуулиар) Эдгээрээс аж үйлдвэрийн өмчийн 3 бүтээл тус бүрээр сонголтын давхардал үүссэн 6 хуулийн этгээд байсныг нэгтгэн нийт 94 хувь хүн, хуулийн этгээдийг судалгаанд хамруулсан.

Судалгаанд хамрагсдын 210 шинэ бүтээл, 247 ашигтай загвар, 221 бүтээгдэхүүний загварын, нийт 678 хүчинтэй патенттай байна.

Судалгаанд хамрагдагсад нийтдээ 1165 шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын 1165 патенттай байна. Эдгээрээс 7 хувь хүн, хуулийн этгээд шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар тус бүр дээр патенттай, 21 нь хувь хүн, хуулийн этгээд шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар тус бүрийн 2 дээр патенттай, 66 нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар тус бүр дээр патенттай байна.

Судалгаанд хамрагдагсдын 80 буюу 86,0% нь хуулийн этгээд, 13 буюу 14,0% нь хувь хүн байна. Судалгаанд хамрагдсан патент эзэмшигчдийн ихэнх нь буюу нь 84 (87,5%) нь Улаанбаатарт, 12 (12,5%) нь хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулдаг байна.

Патентын тоогоор авч нутаг дэвсгэрийн хувьд авч үзэхэд Улаанбаатар хотод 614 (92,0%) үлдсэн 64 (9,4%) нь хөдөө орон нутгийнх байна. Хамгийн их 181 (26,6%) нь Сүхбаатар дүүрэгт, 167(24,6%) нь Баянзүрх дүүргийнх байхад, орон нутгаас Дархан-Уул аймагт 17 патент хамаардаг байна.

Судалгаанд хамрагдагсдыг аж шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвараар авч үзэхэд нийслэлийн дүүргүүд ихэнх патентыг эзэлж байгаа ч гэсэн онцлон Баянзүрх дүүрэг бүтээгдэхүүний загварын 81 патент буюу нийслэлийн бүтээгдэхүүний загварын 36,9%-ийг, Дархан-Уул аймаг 17 буюу ашигтай загварын аймгуудынхаа 40,4%-ийг, Сүхбаатар дүүрэг 79 буюу 39,5%-ийн патент эзэмшиж байна. Эдгээрээс хуулийн этгээдээр нь онцлон авч үзвэл олон патен эзэмшдэг томоохон хуулийн этгээд эдгээр дүүрэг, аймагт байдагтай холбоотой байна.

Судалгаанд хамрагдагсдыг шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патентын тоогоор эрэмбэлэн авч үзэхэд Сүхбаатар дүүрэг шинэ бүтээлийн 79, ашигтай загварын 71, бүтээгдэхүүний загварын 31 патенттай байна. Дүүргүүдээс Налайх, аймгуудаас 12 аймгийн патент уг судалгааны олон патент эзэмшигчийн шалгуурыг хангаагүй байна.

Патент эзэмшигчдээс хамгийн олон эрхийн хамгаалалттай байгууллага МУИС (57 патент) байдаг байхад хөдөө аж ахуйн чиглэлээр олон патент эзэмшдэг А.Чойжамц (хүчинтэй байгаа 14) гэсэн иргэн байна.

Шинэ бүтээлээр МУИС 44 патент, ашигтай загвараар Улаанбаатар төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэг 27, бүтээгдэхүүний загвараар Байгаль Хаус ХХК 41 патент тус тус эзэмшиж байна.

Судалгаанд үндэсний томоохон үйлдвэрлэгчид, судалгаа шинжилгээний томоохон хүрээлэн, хүнс үйлдвэрлэгч, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, татвар төлөгч томоохон байгууллагууд, банк санхүүгийн байгууллагууд, их сургуулиуд болон бусад хуулийн этгээд, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн төлөөллийг бүрэн хамарсан төлөөлөх чадвар сайтай түүвэр болсон байна.

Нийт судалгаанд хамрагдагсдын патентыг олон улсын ангилалаар авч үзэхэд **шинэ бүтээл, ашигтай загварын хувьд** хүний хэрэгцээг хангах зүйлс 57(36,5%), хими төмөрлөг 37 (23,7%), технологийн төрөл бүрийн арга 20(12,8%), механик, гэрэлтүүлэг, дулаан, шахуурга, хөдөлгүүр, зэвсэг, тэсрэх бодис 10(6,4%), цахилгаан, физик, барилга-уул уурхайн ангиллыг тус бүр 9(5,7%), нэхмэлийнх 5 (3,2%) байна.

Шинэ бүтээл, ашигтай загварын патентын ангилалаас хүний хэрэгцээг хангах зүйлс 36,5% хувь буюу бусад ангиллаас хамгийн их хувийг эзэлж байна. Харин нэхмэлийн ангилал хамгийн бага буюу 3,2%-ийг эзэлж байна. Эндээс дүгнэхэд судалгаанд хамрагдагсдын хийсэн бүтээлийн дийлэнх буюу 36,5% нь хүний хэрэгцээг хангах зүйлсийн ангилалын шинэ бүтээл, ашигтай загварын патенттай байна.

Бүтээгдэхүүний загварын судалгаанд хамрагдагсдыг ангилалаар авч үзэхэд нийт 26 ангилалаар патент авсан аж ахуйн нэг, иргэд байна.

Бүтээгдэхүүний загварын олон улсын Лакорногийн 32 ангилал байдаг бөгөөд энэ ангилалаар судалгаанд хамрагдагсдын патентыг ангилан авч үзье. Судалгаанд хамрагдагсдыг патентын ангилалаар хамгийн их нь 19-08 болох бусад хэвлэмэл зүйлс, шошгийн ангилал хамгийн их 22 буюу нийт ангилалын 30,1%-ийг эзэлж байна. Харин 09-03 болох хайрцаг, гэр, сав, ундааны болон консервны лаазны ангилал 12 буюу нийт ангилалын 16,4%-ийг эзэлж байна.

Бүтээгдэхүүний загварын олон улсын Лакорногийн ангилалаар ерөнхийгөөр нь судалгаанд хамрагдагсдын ангилалыг эрэмбэлэн авч үзэхэд 59 нь буюу 80,8% нь хувцас ба бусад жижиг тоног хэрэгсэл, тэмдэг ангиллын патентыг судалгаанд хамрагдагсад эзэмшдэг байна.

Засгийн газрын 2012 оны 101 дүгээр тогтоолоор баталсан “Цахим засаг” үндэсний хөтөлбөр болон ДООБ-тай байгуулсан “Мэдээллийн технологийн чиглэлээр хамтран ажиллах тухай гэрээ”-ний хүрээнд Монгол Улсад эрхийн хамгаалалт хийгдсэн барааны тэмдгийн мэдээллийн санг WIPO PUBLISH системийг ашиглан Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын Дэлхийн брэндийн мэдээллийн сантай (Global Brand Database), Монгол Улсад эрхийн хамгаалалт хийгдсэн бүтээгдэхүүний загварын мэдээллийн санг Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагын Дэлхийн дизайны мэдээллийн сантай холбох ажлыг зохион байгуулсан. Энэхүү мэдээллийн сангуудад өнөөгийн байдлаар Монгол Улсад эрхийн хамгаалалт хийгдсэн 76767 барааны тэмдэг, 2951 бүтээгдэхүүний загварын мэдээлэл орсон.

“Цахим засаг” үндэсний хөтөлбөрийн “Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй болгох” зорилтын хүрээнд барааны тэмдгийн эрхийн хамгаалалтын үйл ажиллагааг илүү хяналттай, өндөр бүтээмжтэй болгох зорилгоор ДООБ-ын WIPO IPAS /Аж үйлдвэрийн өмчийн удирдлагын систем/ системийг суурилуулж, 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс үйл ажиллагаандаа бүрэн ашиглаж эхлээд байна.

Оюуны өмчийн аж үйлдвэрийн өмчийн цахим сан болох PUBLISH.IPOM.MN системд 1963 оноос хойш эрхийн хамгаалалт хийгдсэн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент, ашигтай загвар, үндэсний болон олон улсын барааны тэмдэг, газар зүйн заалтын мэдээллийн санг цахимжуулж олон нийтэд нээлттэй болгосон. Мөн EFILING.IPOM.MN цахим мэдүүлгийн системийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нар 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн ашиглаж байна.

Оюуны өмчийн мэдээллийн сангаас аж үйлдвэрийн өмчийн шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын зарим мэдээллийг сонгон авч нэгтгэлээ.

Оюуны өмчийн мэдээллийн санд шинэ бүтээлээр 5996, ашигтай загвараар 4527, бүтээгдэхүүний загвараар 3674, нийт 14197 мэдүүлэг байна. (2021 оны 10 сарын 4-ны

байдлаар) Нийт мэдүүлгийн 42,2% -ийг шинэ бүтээл, 31,8%-ийг ашигтай загвар, 25,8%-ийг бүтээгдэхүүний загвар эзэлж байна. (аж үйлдвэрийн өмчийн 3 бүтээлийн хувьд)

Хүчинтэй патентыг 2021 оны 10 сарын 4-ны байдлаар авч үзвэл шинэ бүтээлийн 1393, ашигтай загварын 1045, бүтээгдэхүүний загварын 654 патент хүчинтэй байгаа буюу эрх нь хамгаалагдаж байна.

Хүчинтэй патентын тухайд сүүлийн 10 жилээр авч үзвэл хамгийн их нь 2020 онд ашигтай загварын (197), 2015 онд шинэ бүтээлийн (180), 2019 онд шинэ бүтээлийн (177), ашигтай загварын (178) патент байна. 10 жилийн дунджаар авч үзвэл шинэ бүтээлээр 131, ашигтай загвараар 145, бүтээгдэхүүний загвараар 102 патент хүчинтэй байсан байна. (2021 оныхыг 10 сарын 4 байдлаар оруулав.)

Сүүлийн 3 жилийн хугацаанд хүчинтэй шинэ бүтээлийн тоо тогтмол өссөн байхад, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар буурсан үзүүлэлттэй байна. 2021 оны 10 сарын патентын тоог урьд оны энэ үетэй харьцуулахад хүчинтэй патентын тоо өссөн байна.

Мэдүүлгийг цаасаар Оюуны өмчийн газар авахаас гадна 2018 оноос цахимаар хүлээн авдаг болсон байна. Ингэснээр цаг хугацаа, нууцлал, хяналт сайжирсан бөгөөд 2021 оны 10 сарын 04-ны хооронд 359 мэдүүлэг ирсэн байна. Цахимаар ирэх мэдүүлгийн тоо жил ирэх тусам өссөн байна. Жилд дунджаар 90 гаруй мэдүүлэг цахимаар ирсэн байна.

Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийг тоог улс орноор ангилан авч үзвэл 1979 оноос эхлэн мэдүүлгүүд ирсэн байна. Сүүлийн жилүүдэд мэдүүлгийн тоо өсөх хандлагатай байна. 2011 оноос хойш буюу сүүлийн 10 жилийн байдлаар авч үзэхэд 19 улс орноос мэдүүлэг ирсэн ба Монгол улс 1789, АНУ 230, Герман 118, БНХАУ 101, бусад улсууд 100-аас бага тоотой мэдүүлэг ирүүлжээ.

Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг улс орны хувьд сүүлийн 10 жилд тогмол 2100-2400 гийн хооронд байна. Улсуудын хувьд ч мэдүүлэг өгдөг идэвхтэй улс орнууд жил бүр адил тооны мэдүүлэг илгээдэг байна. Монгол улсын тоог хасаж тооцоход нийт гадаад улс орнуудаас хамгийн их нь АНУ 230, нийт гадаад улсуудын мэдүүлгийн 28,1%, ХБНГУ 14,46%, БНХАУ 12,3% тус тус эзэлж байна.

Шинэ бүтээлийн нийт патентын мэдүүлгийн 4413 буюу 73,5%-д нь патент олгогдсон байна. Үүнээс 2398 (54,3%) нь дотоодын, 1851 (41,8%) нь РСТ, 163 (3,6%) нь Парисын конвенцийн дагуу давамгайлах эрх үүсч патент олгогдсон байна.

Шинэ бүтээлийн нийт патентын мэдүүлгийн 5279 буюу 88,0% буюу нь 1992 оноос энэ оныг хүртэл ирсэн байгаа бөгөөд патент олгосон байдлыг авч үзвэл 4413 буюу 1992-2021 оны 10 сарын 4-ны хүртэлх нийт патентын 83,5% нь патент эзэмших эрхээ авсан байна.

1991 оноос мэдүүлгийн тоо өссөн бөгөөд эдгээр жилүүдэд дунджаар жилд 176 шинэ бүтээлийн мэдүүлэг хүлээн авдаг байна. Шинэ бүтээлийн патентын мэдүүлэг 2011-2017 онуудад хамгийн их байсан бөгөөд эдгээр жилүүдэд дунджаар 233 ирсэн байна. 2013 онд хамгийн их буюу 268 патентын мэдүүлэг иржээ. Патентын мэдүүлгийн тоо өсөлт бууралттай байгаа шалтгааныг цаашид нарийвчлан судалж, нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах хэрэгцээ байгаа нь харагдаж байна.

Патент олгосон байдлыг авч үзэхэд мэдүүлгийн тооноос хамааран патент олгогддог болох нь харагдаж байна. Мэдүүлгийн тоотой олгосон патентын тоо харилцан хамааралтай байна.

Ашигтай загварын патентын мэдүүлгийг 1999 оноос авч эхэлсэн бөгөөд 4527 мэдүүлэг Оюуны өмчийн мэдээллийн санд байгаа бөгөөд эдгээрийн 4507 буюу 99,5% нь дотоодын, 20 буюу 0,4% нь гадаадын мэдүүлэг байна.

Ашигтай загварын нийт патентын мэдүүлгийн 3388 буюу 74,8%-д нь патент олгогдсон байна. Үүнээс 3355 (99,0%) нь дотоодын, 33 (1,0%) нь гадаадын мэдүүлэгт патент олгогдсон байна.

Ашигтай загварын патентын мэдүүлэг 2002-2005 онуудад эрчимтэй (1214 мэдүүлэг ба нийт мэдүүлгийн 26,8%), 2017 оноос хойш тасралтгүй өссөн (жилд дунджаар 226 мэдүүлэг) үзүүлэлттэй байгаа нь хүснэгтээс харагдаж байна. 2002 онд 316, 2004 онд хамгийн их буюу 367 мэдүүлэг тус тус иржээ.

Бүтээгдэхүүний загварын патентын үндэсний мэдүүлгийн 3079-д нь патент олгогдсон байна. Үндэсний патентын дотоодын 2902 нь гадаадын 177, Гаагийн хэлэлцээрийн дагуу Монгол улсын нэр зааж бүртгэгдсэн гадаадын патентын мэдүүлэг 5099 патент олгогдсон байна.

Бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг 1965 оноос эхэлсэн бөгөөд 1991 оноос үндэсний мэдүүлгийн тоо өссөн бөгөөд 1997 оноос эхлэн Гаагийн мэдүүлэг тасралтгүй өссөн байна. 1991 оноос одоог хүртэлх хугацаанд бүх мэдүүлгийн 8403 буюу 94,5% нь ирсэн байна. 2017 онд 163, 2020 онд хамгийн их буюу 180 дотоодын бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг иржээ.

Шинэ патентийн тухай хуульд 3.1.13.“патентын олон улсын ангилал” гэж 1971 оны Патентын олон улсын ангиллын тухай Страсбургийн хэлэлцээрээр баталж, нэмэлт, өөрчлөлт оруулсан Патентын олон улсын ангилалыг ойлгоно гэж заасан байдаг.

Оюуны өмчийн мэдээллийн сангаас шинэ бүтээл, ашигтай загварын нийт патентыг ангилалаар авч үзэхэд (IPOM publish) химийн ангилалд 2909 буюу нийт ангилалын 39,9%, механикийн 1630(22,1%), тоног төхөөрөмжийн 780(10,5%), цахилгааных 331(4,4%) тус тус эзэлж байна.

Шинэ бүтээл, ашигтай загварын ангилалаас үзэхэд химийн ангилал нийт бүтээлийн 39,4%-ийг эзэлж байна. Эндээс үзэхэд химийн шинэ бүтээл, ашигтай загварын оюуны бүтээл эрхлэгчид ихээхэн бүтээл хийж патентаа авч эрхээ хамгаалуулдаг нь харагдаж байна. Мөн химийн ангилал патентад өргөн утгаар хэрэглэгддэгтэй ч холбоотой байж болно. Энэ чиглэлийн судалгааг байнга хийж, ямар чиглэлийн хэрэгцээ шаардлага нийгэмд үүсээд бүтээл ихэвчлэн байгаа, эдийн засгийн эргэлтэд бүтээлээ оруулж чаддаг эсэхийг хэрэгтэй нь харагдаж байна.

Бүтээгдэхүүний загварыг ангилж авч үзэхэд нийтлэг 13 ангилалд патент хуваагдаж байна. Эдгээрээс ноос, ноолуур, түүний дагалдах хэрэгсэлийн ангилал хамгийн их 966 буюу ангилалыхаа 27,7%-ийг эзэлж байна. Соёл ба боловсролын ангилал 938 (26,9%), сав, баглаа боодол 587 (16,8%), тавилга, гэр ахуйн бараа 442(12,7%), барилга, байгууламжийн ангилал 145(4.1%), хөдөө, аж ахуйн бүтээгдэхүүн, хоол хүнс 127(3,6%), багаж хэрэгсэл, мэдээллийн технологи ба дуу авиа, тээвэр, зар сурталчилгаа, эрүүл мэнд, гоо сайхан, цахилгаан гэрэлтүүлгийн ангилал 209(6,0%)-ийг тус тус эзэлж байна. Ангилалдаагүй 66 байна.

Бүтээгдэхүүний загварын патентыг ангилалаар эрэмбэлэн авч үзвэл ноос ноолуур, түүний дагалдах хэрэгслийн ангилал хамгийн их буюу 966(27,7%) байна Эндээс үзэхэд ноос, ноолуур түүний дагалдах хэрэгслийн үйлдвэрлэл Монгол улсын голлох салбар бөгөөд энэ чиглэлийн бүтээгдэхүүний загварын патент ихээхэн авдаг байна.

Судалгаанд хамрагдсан 94 хувь хүн, хуулийн этгээдээс судалгаанд 98 асуулга хүчинтэй байсан. Эдгээрээс судалгааны үр дүнг нэгтгэн гаргалаа.

Судалгаанд хамрагдагсдын 13 буюу 13,3% нь шинэ бүтээлийн, 36(36.7%) нь ашигтай загварын, 21(21,4%) нь бүтээгдэхүүний загварын, 14(14,3%) нь шинэ бүтээл, ашигтай загварын, 4(4,1%) нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын, 5(5,1%) нь бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын, 5(5,1%) нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент эзэмшигч байна.

Хамгаалагдсан патентаа ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг нь хүртэж чадаж байгаа эсэх асуултыг патент эзэмшигчдээс асуун аж үйлдвэрийн өмч тус бүрээр хэрхэн хариулсныг авч үзье.

Хамгаалагдсан патентаа ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг нь хүртэж чадаж байгаа эсэх асуултыг патент эзэмшигчдээс асуухад шинэ бүтээлийн патент эзэмшигч 36 хуулийн этгээд, хувь хүмүүсээс 18(18,4%) нь патентаа эдийн засгийн эргэлтэд оруулсан, 12(12,%) нь үгүй, 6(16,6%) нь хариулаагүй байна.

Шинэ бүтээлээ патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж патентын үр ашгийг хүртэж байгаа хуулийн этгээд, хувь хүмүүсийн 4 буюу 22,0% нь шинэ бүтээл, 8 буюу 44,0% нь шинэ бүтээл, ашигтай загварын, 3 буюу 17,0% нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын үлдсэн 3 буюу 17,0% нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын патент эзэмшигчид байна. Эндээс үзэхэд аж үйлдвэрийн өмчийн шинэ бүтээл, ашигтай загварын патенттай эзэмшигч бусдаасаа арай олон тоотойгоор патентаа эдийн засгийн эргэлтэд оруулан үр ашгийг нь хүртсэн гэсэн байна.

Патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашигаа хүртэж буй патент эзэмшигчдийг байшилаар нь авч үзэхэд хамгийн их буюу нийслэлийн Баянзүрх дүүрэг 28%, 17% нь Хан-Уул, Сүхбаатар дүүргийн, орон нутгаас Орхон аймгийнх 11%-ийг тус тус байна.

Хамгаалагдсан патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашигаа хүртээгүй патент эзэмшигчдыг авч үзэхэд судалгааны асуулгад хариулсан оролцогчдын шинэ бүтээлийн 42%, шинэ бүтээл, ашигтай загвар адил 42%, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвартай, мөн аж үйлдвэрийн 3 патенттай нь адилхан 8%-ийг эзэлж байна.

Шинэ бүтээлийн патент эзэмшин эдийн засгийн эргэлтэд патентаа оруулан үр ашигаа хүртэж байгаа хуулийн этгээд, хувь хүмүүсээс ямар хэлбэрээр үр ашиг хүртэж байгааг тодруулахад 81,0% нь бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулан, 19,0% нь лиценз болон бусад гэрээгээр ашиглуулдаг гэсэн байна. Эндээс үзэхэд шинэ бүтээлийн патент эзэмшигчдийн ихэнх буюу 81,0% нь патентаа ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулан патентаа эдийн засгийн эргэлтэд оруулан үр ашигаа хүртэж байна.

Шинэ бүтээлийн патент эзэмшигчдийн эдийн засгийн эргэлтэд патентаа оруулан үр ашигаа хүртэж байгааг хуулийн этгээд, хувь хүн байгаа эсэхийг тодруулахад 1-ээс бусад нь хуулийн этгээд патент эзэмшигч байна.

Шинэ бүтээлийн патент эзэмшигчдийн эдийн засгийн эргэлтэд патентаа оруулан үр ашигаа хүртээгүй патент эзэмшигчдийн ямар шалтгаанаар хамгаалагдсан патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг хүртэж чадахгүй байгааг тодруулахад шинэ бүтээлийн патент эзэмшигчдийн патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж чадахгүй байгаа шалтгаан нь ойлголт, туршлага, мэдлэг, мэдээлэл дутмагаас 9(31,0%), хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг хомсоос 8(27,6%), хууль, эрх зүйн орчноос 7(24,1%), бусад шалтгааны улмаас 5(17,2%) тус бүр болдог гэж үзсэн байна.

Шинэ бүтээлийн патент эзэмшигчдийн эдийн засгийн эргэлтэд патентаа оруулан үр ашигаа хүртээгүй патент эзэмшигчдийн ямар шалтгаанаар хамгаалагдсан патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг хүртэж чадахгүй байгааг тодруулахад хамгаалагдсан патентаа

ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг нь хүртэж чадаж байгаа эсэх асуултыг патент эзэмшигчдээс асуухад ашигтай загварын бүтээлийн патент эзэмшигч 60 хуулийн этгээд, хувь хүмүүсээс 17(28,0%) нь патентаа эдийн засгийн эргэлтэд оруулсан, 16(27%) нь үгүй, 27(45%) нь хариулаагүй байна.

Ашигтай загварын патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж патентын үр ашгийг хүртэж байгаа хуулийн этгээд, хувь хүмүүсийн 36 буюу 66,0% нь ашигтай загвар, 14 буюу 24,0% нь шинэ бүтээл, ашигтай загвар, 5 буюу 8,0% нь бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын, мөн үлдсэн 5 буюу 8,0% нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын патент эзэмшигчид байна. Эндээс үзэхэд аж үйлдвэрийн өмчийн дан ганц ашигтай загварын патенттай эзэмшигч бусдаасаа арай олон тоотойгоор патентаа эдийн засгийн эргэлтэд оруулан үр ашгийг нь хүртсэн байна.

Патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашигаа хүртэж буй патент эзэмшигчдийг байршилаар авч үзэхэд хамгийн их буюу нийслэлийн Баянгол дүүрэг 23,0%, Хан-Уул дүүрэг 18%, Сонгинохайрхан дүүрэг 17,0%, Сүхбаатар дүүрэг 12,0%, Баянзүрх дүүрэг 6%, орон нутгаас Орхон, Сүхбаатар, Өмнөговь аймаг тус тус 6,0% байна.

Ашигтай загварын патент эзэмшигчдийн эдийн засгийн эргэлтэд патентаа оруулан үр ашигаа хүртэж байгааг хуулийн этгээд, хувь хүн байгаа эсэхийг тодруулахад 14 буюу 82,3% нь хуулийн этгээд, 3 буюу 17,6% нь хувь хүн байна.

Хамгаалагдсан патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашигаа хүртээгүй 16 патент эзэмшигчдыг авч үзэхэд судалгааны асуулгад хариулсан оролцогчдын ашигтай загварын бүтээлийн 50%, шинэ бүтээл, ашигтай загвар 31%, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, Ашигтай загварын патенттай нь 13%, Бүтээгдэхүүний загвар, Ашигтай загвар-ийн патенттай нь 6%-ийг эзэлж байна.

Ашигтай загварын бүтээлийн патент эзэмшин, эдийн засгийн эргэлтэд патентаа оруулан үр ашигаа хүртэж байгаа хуулийн этгээд, хувь хүмүүсээс ямар хэлбэрээр үр ашиг хүртэж байгааг тодруулахад 81,0% нь бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулан, 13,0 хувь нь лиценз болон бусад гэрээгээр ашиглуулан, мөн 6% нь бусад буюу патентаа худалдах гэсэн байна.

Хамгаалагдсан патентаа ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг нь хүртэж чадаж байгаа эсэх асуултыг бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчдээс асуухад бүтээгдэхүүний загварын патент эзэмшигч 36 хуулийн этгээд, хувь хүмүүсээс 24(66,6%) нь патентаа эдийн засгийн эргэлтэд оруулсан, 6(16,6%) нь оруулаагүй, 6(16,6%) нь хариулаагүй байна.

Бүтээгдэхүүний загварын патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж патентын үр ашгийг хүртэж байгаа хуулийн этгээд, хувь хүмүүсийн 16 буюу 66,7% нь бүтээгдэхүүний загвар, 3 буюу 12,5% нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын, 3 буюу 12,5% нь бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын үлдсэн 2 буюу 8,3% нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын патент эзэмшигчид байна.

Патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашигаа хүртэж буй патент эзэмшигчдийг байршилаар нь авч үзэхэд хамгийн их буюу нийслэлийн Баянзүрх дүүрэг 25%, Сонгинохайрхан дүүрэг 17%, Сүхбаатар дүүрэг 12%, Хан-Уул дүүрэг 25%, Чингэлтэй дүүрэг 4%, Баянгол дүүрэг 17%-ийг тус тус байна.

Бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчдийн эдийн засгийн эргэлтэд патентаа оруулан үр ашигаа хүртэж байгааг хуулийн этгээд, хувь хүн байгаа эсэхийг тодруулахад 22 буюу 91,6% нь хуулийн этгээд, 2 буюу 8,3% нь хувь хүн байна.

Хамгаалагдсан патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашигаа хүртээгүй патент эзэмшигчдийг авч үзэхэд судалгааны асуулгад хариулсан оролцогчдын 66,6% нь бүтээгдэхүүний загварын, 33,3% нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварынх байна.

Бүтээгдэхүүний загварын патент эзэмшин эдийн засгийн эргэлтэд патентаа оруулан үр ашигаа хүртэж байгаа хуулийн этгээд, хувь хүмүүсээс ямар хэлбэрээр үр ашиг хүртэж байгааг тодруулахад 82,0% нь бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулан, 14,0 хувь нь лиценз болон бусад гэрээгээр ашиглуулдаг, 3,6% нь патентаа худалдах гэх мэтээр ашигладаг гэсэн байна. Эндээс үзэхэд бүтээгдэхүүний загварын патентаа ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг нь хүртэгсдийн ихэнх буюу 82,1% нь патентаа ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулан патентаа эдийн засгийн эргэлтэд оруулан үр ашигаа хүртэж байна.

Бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчдийн эдийн засгийн эргэлтэд патентаа оруулан үр ашигаа хүртэж чадаагүй хувь хүн, хуулийн этгээдээс ямар шалтгаанаар хамгаалагдсан патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг хүртэж чадахгүй байгааг тодруулахад бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчдийн патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж чадахгүй байгаа шалтгаан нь ойлголт, туршлага, мэдлэг, мэдээлэл дутмагаас хууль, эрх зүйн орчноос 37,5%, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг хомсоос 31,2% тус бүр болдог гэж үзсэн байна.

Судалгаанд хамрагдагсдаас хөрөнгийн үнэлгээ хийлгэдэг эсэхийг асуухад 9 патент эзэмшигчид хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн гэсэн байна. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдагсдын 9,1% нь хөрөнгийн үнэлгээг хийлгэсэн байна.

Хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн патент эзэмшигчдын 44,4% нь шинэ бүтээл, ашигтай загварын, 22,2% нь ашигтай загварын, 11,1% нь бүтээгдэхүүний загварын, 11,1% нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент эзэмшигчид байна. Эдгээрийн 7 нь буюу 77,7% нь хуулийн этгээд, 2 буюу 22,2% нь хувь хүн байна.

Үнэлүүлсэн патентын тоог авч үзэхэд 1 бүтээлээ үнэлүүлсэн 7, 4 бүтээлээ үнэлүүлсэн 1, 5 бүтээлээ үнэлүүлсэн 1 патент эзэмшигчид байна.

Үнэлүүлсэн үнийн дүнг тодруулахад 200 мянгаас 1,2 тэрбум төгрөгөөр патентаа үнэлүүлжээ. Хамгийн өндөр үнээр үнэлүүлсэн патент эзэмшигчийг тодруулахад шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент эзэмшдэг Чиглэл ХХК байна. Шинэ бүтээлийн патентыг үнэлсэн үнэлгээний үнийн дүн бусад патент эзэмшигчдийхээс өндрөөр үнэлэгдсэн байна.

4.2 САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Судалгаанд хамрагдагсдөөс өгсөн санал, зөвлөмжийг нэгтгэлээ.

Нэг. Оюуны өмчийн талаарх мэдээ, мэдээллийг олон нийтэд түгээх, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар

- Оюуны өмчийн талаарх сургалтад патент эзэмшигчдийг хамруулдаг байх, оюуны өмчийн бүтээлээ хэрхэн эдийн засгийн эргэлтэнд оруулах тухай зөвлөгөө, зөвлөмжийг хариуцсан байгууллагуудаас өгдөг байх
- Шинээр бүтсэн бүтээлийг хөрөнгө оруулагч, үйлдвэрийн газрын удирдлагууд болон бусдад таниулан мэдээ, мэдээлэл хүргэн сурталчилдаг байх
- Оюуны бүтээл, эд хөрөнгөөс илүү үнэ цэнэтэйг нийгэмд ойлгуулах мэдээ, мэдээлэл, сурталчилгааг байнга өгөх
- Оюуны өмч, түүнийг хэрхэн хамгаалах талаар нэгдсэн мэдээлэл, зөвлөгөө өгөх төв эсвэл утас, мэргэжилтэн байлгах
- Олон нийтэд оюуны өмчийн талаарх мэдлэг ойлголтыг ойлгоход хялбар богино хэмжээний кино, клип, анимэйшн хэлбэрээр түгээх, эерэг хандлага бий болгоход түлхэц өгөх
- Хүүхэд багачуудад багаас нь инноваци шинэ бүтээл хөгжлийн гол түлхүүр гэдгийг сурталчилан таниулах, оюуны бүтээлийн талаарх энгийн ойлголтыг өгдөг байх, хүний бүтээлийг зөвшөөрөлгүй хэрэглэх эрхгүйг ойлгуулан үлгэр, ном зохиол болон сургалтын агуулгад оруулах
- Үндэсний өв уламжлалаар дамжуулан оюуны өмчийн бүтээлийн талаарх ойлголтыг олон нийтэд түгээх
- Инноваци шинэ бүтээгдэхүүний уралдаан зарлаж, санхүүжүүлж, бизнесийн багийг бүрдүүлэх, патент эзэмшигчдийг дэмжих, түүгээр дамжуулан олон нийтэд сурталчилах

Хоёр. Хөрөнгө санхүү, татварын бодлогоор патент эзэмшигчдийг дэмжих, эрх зүйн орчинг сайжруулах талаар

- Дотоодын үйлдвэрлэл эрхлэгч хуулийн этгээд, хувь хүн рүү чиглэсэн бодлого хэрэгжүүлэх
- Оюуны өмчийн татвар авдагийг багасгах, татварын бодлогоор патент эзэмшигчдийг дэмжих
- Патентыг олон улсад бүртгүүлэх хураамж болон олон улсын мэдүүлэг өгөхөд дэмжлэг үзүүлж, хамгаалалт тал дээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх
- Салбарын хариуцсан яамд шинэ бүтээлийн патентыг судалж үйлдвэрлэлд нэвтрүүлэх, ашиглах талаар тодорхой бодлогоор дэмжин хөрөнгө төсөвлөдөг байх
- Жижиг дунд бизнес эрхэлдэг оюуны өмчөө баталгаажуулсан хүмүүст хөнгөлттэй зээл, тусламж, батлан даалт хийх зэргээр бодитой дэмжлэг өгдөг тогтолцоо бий болгох, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, сайжруулах
- Хөрөнгө оруулалт дэмжин бодлогоор төрийн байгууллагууд туслах
- Хууль эрх зүйн орчинг чангатгаж, оюуны өмч эзэмшиж буй эзэмшигчдийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэнд оруулахад боломж олгох
- Оюуны өмчийн шинэ хуулийн дагалдах журмуудыг гаргах, олон нийтэд хүргэх, таниулах

Гурав. Судалгаа, шинжилгээний ажлын талаар

- Эдийн засгийн эргэлтэд оруулж буй талаарх судалгаанд хамрагдагсдыг тоог нэмэгдүүлэн байнгын, давталттай өргөн хүрээтэй авдаг болох
- Оюуны өмчийн талаар цогц судалгааг зохион байгуулах
- Патент эзэмшигч, мэдүүлэг гаргагчдаас асуулга авдаг байх

Дөрөв. Оюуны өмчийг хамгаалах талаар

- Эдийн засгийн эргэлтэд оруулах явцад бусад хуулан дууриах асуудал гарч байгааг судлан, оюуны бүтээлийн хулгайн асуудлыг шийдвэрлэх, дотоод гадаадын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах

Тав. Хөрөнгийн үнэлгээ хийлгэх талаар

- Оюуны өмчийн үнэлгээ хийх эрх зүйн орчинг тодорхой болгох, иргэдэд мэдээллийг тодорхой болгон хүргэх, өндрөөр үнэлдэг байх, нарийвчилсан дүрэм журам гаргах
- Патентаа үнэлэх дүрэм журам бий болгох, сайжруулах
- Үнэлгээ хийдэг мэргэжлийн байгуулага, үнэлгээчилтэй болох
- Патент эзэмшигчдэд үнэлгээ хийх талаар мэдээлэл, сургалт зохион байгуулдаг байх

ТАВ. ХАВСРАЛТ

5.1 СУДАЛГААНЫ АСУУЛГА



ОЮУНЫ ӨМЧИЙН БҮТЭЭЛИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛАН, ҮР АШГАА ДЭЭШЛҮҮЛЖ БУЙ ТАЛААРХ СУДАЛГАА

Оюуны өмчийн бүтээл эдийн засгийн эргэлтэд орж үр ашиг дээшилж байгаа эсэхэд судалгаа хийж, эдийн засгийн эргэлтэд оруулахад тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх, бодлого боловсруулагчдад санал хүргүүлэх, алдаршуулан сурталчилах, туршлага солилцох зорилгоор асуулга бэлтгэн танд хүргүүлж байна.

Патент эзэмшигч та энэхүү судалгаанд хамрагдан оюуны өмчийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж байгаа юм. Судалгааны мэдээллийг манай байгууллагын зөвхөн дотоод хэрэгцээнд ашиглах болно. Асуулгыг үнэн зөв бөгөж бидний ажилд туслана уу.

Та тохирох асуултын аль нэгийг сонгон ✓ тэмдэг тавих буюу хариултыг бичнэ үү.

1. Патент эзэмшигчийн нэр _____
2. Та хамгаалагдсан патентаа ашиглаж, эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг нь хүртэж чадаж байна уу?

		Шинэ бүтээл	Ашигтай загвар	Бүтээгдэхүүний загвар
2.1	Тийм			
2.2	Үгүй			

3. Хэрэв тийм бол ямар хэлбэрээр үр ашиг хүртэж байгаа вэ?

		Шинэ бүтээл	Ашигтай загвар	Бүтээгдэхүүний загвар
3.1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулах			
3.2	Лиценз болон бусад гэрээгээр ашиглуулах			
3.3	Бусад (патентаа худалдах гэх мэт)			

4. Хэрэв үгүй бол ямар шалтгаанаар хамгаалагдсан патентаа эдийн засгийн эргэлтэд оруулж, үр ашгийг хүртэж чадахгүй байна вэ?

- 4.1 Хууль, эрх зүйн орчин
- 4.2 Хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг хомс
- 4.3 Ойлголт, туршлага, мэдлэг мэдээлэл дутмаг
- 4.4 Бусад _____

5. Та патентдаа хөрөнгийн үнэлгээ хийлгэж үнэлүүлсэн үү? Хэрэв тийм бол (татгалзахгүй бол) үнэлүүлсэн бүтээлийн тоог, үнийн дүнтэй нь бичнэ үү?

5.1	Тийм	Үнэлүүлсэн бүтээлийн тоо Үнэлүүлсэн үнийн дүн.....
5.2	Үгүй	

6. Оюуны өмчийн бүтээлээ эдийн засгийн эргэлтэд оруулахтай холбоотой санал хүсэлт байвал бичнэ үү.

.....
.....
.....

Асуулга бөглөсөн хүний нэр, утасны дугаар:

.....

Энэхүү асуулгатай холбоотой асуух асуулт байвал 95959196, 88881203 утсаар холбогдоно уу.

СУДАЛГААНД ОРОЛЦСОН ТАНД БАЯРЛАЛАА

5.2 СУДАЛГААНД ХАМРАГДАГСАД *(Мэдээллийн санд буй нэрээр бичсэн болно.)*

1	Өнөд өвлөх урлахуй ХХК [MN]
2	А.Чойжамц [MN]
3	Б.Эрдэнэбат [MN]
4	Бүрэн хайрхан ээж трейд ХХК [MN]
5	Верса-Өрөм ХХК [MN]
6	Г.ХАЯНХЯРВАА [MN]
7	Д.Мөнхбаяр [MN]
8	Д.Цэрэннадмид [MN]
9	Бэст Энержи Сэйвинг ХХК [MN]
10	Монгол тэмээ корпораци ХХК [MN]
11	МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ [MN]
12	Монфүүд Ланд ХХК [MN]
13	САРАНГЭРЭЛ САН [MN]
14	Х. Ганбаатар [MN]
15	ХААИС-ийн харъяа Ургамал газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн [MN]
16	Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэн [MN]
17	Ла перла косметик ХХК
18	Ц.Энхбаатар [MN]
19	ШУА, Физик Технологийн Хүрээлэн [MN]
20	ШУТИС -ийн Мэдээлэл, Холбооны Технологийн Сургууль [MN]
21	Э.Лхамсүрэн [MN]
22	Эко тайхи ХХК [MN]
23	Эм судлалын хүрээлэн
24	Хатан сүйх импекс ХХК
25	Биологийн хүрээлэн/ Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн
26	МИЛКО ХХК [MN]
27	Монкрем ХХК
28	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн
29	Грийн ХХК [MN]
30	УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН
31	ШИНЖЛЭХ УХААН ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН БИЛИГ ТӨВ ХХК
32	Монос Хүнс ХХК
33	Улаанбаатар төмөр зам хувь нийлуулсэн нийгэмлэг
34	ТЕСО ХХК
35	Эгшиглэн ХХК
36	ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ХХК [MN]
37	Мал эмнэлгийн хүрээлэн
38	Их тайга
39	Монхимо
40	ШУА, Ерөнхий болон Сорилын Биологийн Хүрээлэн
41	Монголын алт (МАК) ХХК [MN]
42	Өндөр хөгжил ХХК [MN]
43	ШУА, Хими, Химийн Технологийн Хүрээлэн
44	ЖЕМ ИНТЕРНЭШНЛ ХХК
45	Мегавуд ХХК
46	Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн
47	ШУТИС
48	Тавин ус ХХК [MN]
49	4-р цахилгаан станц
50	ХААИС- /МААБС- УГТХ/
51	АПУ
52	Дэлгэр агьт ХХК
53	Моноскосметик ХХК

54	Багануур ХК
55	Таванбогд трейд ХХК
56	Атмор ХХК
57	Эрдэнэт хивс ХХК
58	Говь ХК
59	З. Золжаргал
60	Эм Эн Ти прожект ХХК
61	ШУА Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн
62	Шивээ Овоо ХК
63	Чиглэл ХХК
64	Юнисолван ХХК
65	Таван толгой түлш
66	Байгал Хаус ХХК
67	Атар-Өргөө ХК
68	Сүү ХК
69	А.Намуун, А.Сарнай
70	Энержи ресурс ХХК
71	Эрдэм Гоёл ХХК
72	Б.Бадамханд
73	Минпро ХХК
74	Си ви эс ХХК /СУ/
75	Хүрхрээ долгио хоршоо
76	Три флэймс ХХК/хадлан дээл
77	МОНГОЛ ДАВСАН УРЛАЛ ХХК
78	Худалдаа хөгжлийн банк ХХК
79	Голомт банк ХХК
80	Пекасо ХХК
81	Бэстшүес ХХК
82	Мөнхийн болор ХХК
83	Есөн Од ХХК
84	Хаадын гэр ХХК
85	Мичел Амазонка ХХК
86	Түмэн Торго ХХК
87	Ц.Ганбат/газаршим
88	Их монгол девелопмент ХХК /мимо гэр
89	Си Пи Эл ХХК/вава эсгий гут.
90	Витафит ИмпексХХК/Витафит Инвест ХХК/ Витафит ХХК
91	Талх Чихэр ХК
92	Айсмарк ХХК
93	Өгөөж

5.3 АЖЛЫН ХЭСЭГ, СУДАЛГААНЫ БАГИЙН ГИШҮҮД



ОЮУНЫ ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/103

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Оюуны өмчийн газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.7 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Эдийн засгийн эргэлтэд орж буй Шинэ бүтээл, түүний эзэмшигчийн судалгааг гаргаж мэдээллийн сан үүсгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

С.Ганзориг

-Захиргаа удирдлагын хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Оргилмаа

- Шинэ бүтээл, ашигтай загварын ахлах

шинжээч

Б.Номиндарь

- Бүтээгдэхүүний загварын шинжээч

Ц.Галцогт

- Шинэ бүтээл, ашигтай загварын шинжээч

Нарийн бичгийн дарга:

Ц.Эрдэнэцэцэг

- Шинэ бүтээл, ашигтай загварын шинжээч

2. Тушаалын биелэлтэд хяналт тавьж, судалгааг 2021 оны 10 сарын 31-ны өдөр танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (С.Ганзориг)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЭНХСҮХ



000404

5.4 ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

- ✓ IPAS- Industrial Property Administration System
- ✓ ОАГ-Оюуны өмчийн газар
- ✓ ШУТИС-Шинжлэх ухаан технологийн их сургууль
- ✓ МУИС- Монгол улсын их сургууль
- ✓ ХААИС-Хөдөө аж ахуйн их сургууль
- ✓ ХХК-Хариуцлагатай хувьцаат компани
- ✓ АПУ ХХК- Архи, Пиво, Ундаа хариуцлагатай хувьцаат компани
- ✓ АНУ-Америкийн нэгдсэн хууль
- ✓ БНХАУ-Бүгд найрамдах Хятад ард улс
- ✓ ХБНГУ-Холбооны бүгд найрамдах Герман улс

5.5 ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1 Судалгаанд хамрагдсан хуулийн этгээд, хувь хүний тоо, хувь байршлаар, аймаг, дүүргээр.....	10
Хүснэгт 2 Патентын тоо, шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, аймаг, дүүргээр	11
Хүснэгт 3 Судалгаанд хамрагдагсдын бүтээгдэхүүний загварын патентын тоо, ангилалаар ..	14
Хүснэгт 4 Патентын тоо, хувиар (Нийт болон хүчинтэй)	17
Хүснэгт 5 Цахимаар ирсэн патентын мэдүүлгийн тоо	18
Хүснэгт 6 Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийн тоо, улс, оноор	18
Хүснэгт 7 Шинэ бүтээлийн патентын мэдүүлгийн тоо, оноор	20
Хүснэгт 8 Ашигтай загварын патентын мэдүүлгийн тоо, оноор	22
Хүснэгт 9 Бүтээгдэхүүний загварын мэдүүлэг ба олгосон патентын тоо, оноор	24
Хүснэгт 10 Шинэ бүтээл, ашигтай загварын патентын ангилал, тоо, хувиар	27
Хүснэгт 11 Бүтээгдэхүүний патентын ангилал, тоо, хувиар	28
Хүснэгт 12 Судалгаанд хамрагдагдсан хуулийн этгээд, хувь хүмүүсийн патентын тоо, хувь..	29
Хүснэгт 13. Хөрөнгийн үнэлгээ хийлгэсэн патент эзэмшигчид, тоо, хувиар	40
Хүснэгт 14. Үнэлүүлсэн үнийн дүн, бүтээлийн тоо, үнэ төгрөгөөр.....	40

5.6 ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. СУДАЛГААНЫ АСУУЛГЫН ЗАГВАР (ГҮҮГЛ ФОРМ)	8
ЗУРАГ 2 СУДАЛГААНД ХАМРАГДАГСАД, ПАТЕНТЫН ТООГООР	9
ЗУРАГ 3 СУДАЛГААНД ХАМРАГДАГСДЫН БАЙРШИЛ, НУТАГ, ДЭВСГЭРЭЭР	10
ЗУРАГ 4 ПАТЕНТЫН ТОО, ШИНЭ БҮТЭЭЛ, АШИГТАЙ ЗАГВАР, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАР, АЙМАГ, ДҮҮРГЭЭР	11
ЗУРАГ 5 СУДАЛГААНД ХАМРАГДАГСДЫН ШИНЭ БҮТЭЭЛ, АШИГТАЙ ЗАГВАРЫН ПАТЕНТЫГ АНГИЛЛАЛААР ХАРУУЛСАН БАЙДАЛ	13
ЗУРАГ 6 СУДАЛГААНД ХАМРАГДАГСДЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ПАТЕНТ, ЭРЭМБЭЛСНЭЭР	15
ЗУРАГ 7 ХУЧИНТЭЙ ПАТЕНТЫН ТОО, ШИНЭ БҮТЭЭЛ, АШИГТАЙ ЗАГВАР, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАР, ОНООР	17
ЗУРАГ 8 ШИНЭ БҮТЭЭЛ, АШИГТАЙ ЗАГВАРЫН ПАТЕНТЫН МЭДҮҮЛГИЙН ТОО, УЛС, ХУВИАР	19
ЗУРАГ 9 ШИНЭ БҮТЭЭЛИЙН НИЙТ МЭДҮҮЛГИЙН БОЛОН ОЛГОСОН ПАТЕНТИЙН ТОО.....	21
ЗУРАГ 10 АШИГТАЙ ЗАГВАРЫН ПАТЕНТЫН МЭДҮҮЛГИЙН БОЛОН ОЛГОСОН ПАТЕНТИЙН ТОО	23
ЗУРАГ 11 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ПАТЕНТЫН МЭДҮҮЛГИЙН ТОО, ОНООР.....	25
ЗУРАГ 12 БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ПАТЕНТЫН МЭДҮҮЛГИЙН БОЛОН ОЛГОСОН ПАТЕНТИЙН ТОО	26
ЗУРАГ 13 ШИНЭ БҮТЭЭЛ, АШИГТАЙ ЗАГВАРЫН ПАТЕНТЫН АНГИЛАЛ, ХУВИАР	27
ЗУРАГ 14. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ПАТЕНТЫН АНГИЛАЛ ЭРЭМБЭЛСНЭЭР, ХУВИАР.....	28
ЗУРАГ 15. ШИНЭ БҮТЭЭЛИЙН ПАТЕНТАА ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛСАН ЭСЭХ, ХУВИАР	30
ЗУРАГ 16. ШИНЭ БҮТЭЭЛЭЭ ПАТЕНТАА ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛЖ ПАТЕНТЫН ҮР АШГИЙГ ХҮРТЭЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭД, ХУВЬ ХҮМҮҮСИЙН ЭЗЛЭХ ХУВЬ	30
ЗУРАГ 17. ПАТЕНТАА ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛЖ, ҮР АШИГАА ХҮРТЭЖ БУЙ ПАТЕНТ ЭЗЭМШИГЧИД БАЙРШЛААР	31
ЗУРАГ 18. ШИНЭ БҮТЭЭЛИЙН ПАТЕНТ ЭЗЭМШИГЧИД, ПАТЕНТАА АШИГЛАДАГ ХЭЛБЭРЭЭР, ХУВИАР.....	32
ЗУРАГ 19. ШИНЭ БҮТЭЭЛИЙН ПАТЕНТ ЭЗЭМШИГЧИД, ПАТЕНТАА АШИГЛАЖ ЧАДДАГГҮЙ ШАЛТГААН, ХУВИАР	32
ЗУРАГ 20. АШИГТАЙ ЗАГВАРЫН ПАТЕНТАА ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛСАН ЭСЭХ, ХУВИАР.....	33
ЗУРАГ 21. АШИГТАЙ ЗАГВАРЫН ПАТЕНТАА ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛЖ ПАТЕНТЫН ҮР АШГИЙГ ХҮРТЭЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭД, ХУВЬ ХҮМҮҮСИЙН ПАТЕНТЫН ТОО	33
ЗУРАГ 22. ПАТЕНТАА ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛЖ, ҮР АШИГАА ХҮРТЭЖ БУЙ ПАТЕНТ ЭЗЭМШИГЧИД БАЙРШЛААР	34
ЗУРАГ 23. АШИГТАЙ ЗАГВАРЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ПАТЕНТАА ОРУУЛСАН ПАТЕНТ ЭЗЭМШИГЧИД, ХУУЛИЙН ЭТГЭЭД, ХУВЬ ХҮНЭЭР	35
ЗУРАГ 24. АШИГТАЙ ЗАГВАРЫН ПАТЕНТ ЭЗЭМШИГЧИД, ПАТЕНТАА АШИГЛАЖ БАЙГАА ХЭЛБЭР, ХУВИАР ...	36
ЗУРАГ 25. АШИГТАЙ ЗАГВАРЫН ПАТЕНТ ЭЗЭМШИГЧИД, ПАТЕНТАА АШИГЛАЖ ЧАДДАГГҮЙ ШАЛТГААН, ХУВИАР.....	36
ЗУРАГ 26. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ПАТЕНТАА ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛСАН ЭСЭХ, ХУВИАР	37
ЗУРАГ 27. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ПАТЕНТАА ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛЖ ПАТЕНТЫН ҮР АШГИЙГ ХҮРТЭЖ БАЙГАА ХУУЛИЙН ЭТГЭЭД, ХУВЬ ХҮМҮҮСИЙН ПАТЕНТЫН ЭЗЛЭХ ХУВЬ.....	37
ЗУРАГ 28. ПАТЕНТАА ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛЖ, ҮР АШИГАА ХҮРТЭЖ БУЙ ПАТЕНТ ЭЗЭМШИГЧИД БАЙРШЛААР	38
ЗУРАГ 29. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ПАТЕНТАА ОРУУЛСАН ПАТЕНТ ЭЗЭМШИГЧИД, ХУВЬ ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭР	38
ЗУРАГ 30. ШИНЭ БҮТЭЭЛИЙН ПАТЕНТ ЭЗЭМШИГЧИД, ПАТЕНТАА АШИГЛАДАГ ХЭЛБЭРЭЭР, ХУВИАР.....	39
ЗУРАГ 31. БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАГВАРЫН ПАТЕНТ ЭЗЭМШИГЧИД, ПАТЕНТАА АШИГЛАЖ ЧАДДАГГҮЙ ШАЛТГААН, ХУВИАР	39

5.7 АШИГЛАСАН НОМ, ЭХ СУРВАЛЖ

1. Оюуны өмчийн газар <https://www.ipom.gov.mn>
2. IPOM publish
3. IPAS-<http://db.ipom.mn/>
4. Оюуны өмч гэж юу вэ? <https://www.ipom.gov.mn/source/What%20Is%20IP.pdf>
5. Оюуны өмчийн газрын 2020 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 1/458 дугаар албан бичгийн хавсралт 1

ХУУЛИЙН НЭР ТОМЬЕОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Патентын тухай хуулиас (2021 оны 05 сарын 06 өдөр батлагдсан)

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “албан ёсны тогтмол хэвлэл” гэж Оюуны өмчийн тухай хуулийн 3.1.4-т заасныг;

3.1.2. “анхдагч огноо” гэж энэ хуульд заасан шаардлагыг хангасан патентын мэдүүлгийг оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүлээн авсан он, сар, өдрийг;

3.1.3. “ашигтай загвар” гэж багаж, хэрэгсэл, түүнтэй адилтгах бүтээгдэхүүний бүрэлдэхүүнд хамаарах техникийн шийдлийг;

3.1.4. “бүтээгдэхүүний загвар” гэж бүтээгдэхүүний гадаад харагдах байдалд хамаарах дүрс, хийц, хэлбэр, өнгө, бүтцийн болон хээ чимэглэлийн уран сайхны шийдлийг;

3.1.5. “бүтээгдэхүүний загварын олон улсын ангилал” гэж Бүтээгдэхүүний загварын олон улсын ангилал тогтоох тухай 1968 оны Локарногийн хэлэлцээрээр баталж, нэмэлт, өөрчлөлт оруулсан Бүтээгдэхүүний загварын олон улсын ангиллыг;

3.1.6. “Гаагийн хэлэлцээр” гэж 1999 онд баталж, нэмэлт, өөрчлөлт оруулсан Бүтээгдэхүүний загварын олон улсын бүртгэлийн тухай Гаагийн хэлэлцээрийн Женевийн акт болон түүнийг дагаж гарсан дүрэм, журам, зааврыг;

3.1.7. “давамгайлах огноо” гэж патентын мэдүүлгийн анхдагч огнооноос өмнө Парисын конвенцын, эсхүл Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн аль нэг улсад гаргасан, Парисын конвенцын 4 дүгээр зүйлд заасан хугацаагаар тооцогдох нэг, эсхүл түүнээс дээш патентын мэдүүлгийн он, сар, өдрийг;

3.1.8. “зохион бүтээгч” гэж шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар зохион бүтээсэн хувь хүнийг;

3.1.9. “олон улсын мэдүүлэг” гэж Патентын хамтын ажиллагааны гэрээний дагуу гаргасан шинэ бүтээл, ашигтай загварын патентын олон улсын мэдүүлгийг, эсхүл Гаагийн хэлэлцээрийн дагуу гаргасан бүтээгдэхүүний загварын олон улсын бүртгэлийн мэдүүлгийг;

3.1.10. “Парисын конвенц” гэж 1883 оны 3 дугаар сарын 20-ны өдөр баталж, нэмэлт, өөрчлөлт оруулж, өөрчлөн найруулсан Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенцыг;

3.1.11. “патент” гэж тухайн шийдэл нь шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар болохыг тодорхойлж, патент эзэмшигч нь тодорхой хугацаанд энэ хуулийн 46.2-т заасан онцгой эрхийг эдлэх эрхийг;

3.1.12. “патентын мэдүүлэг” гэж иргэн, хуулийн этгээдээс энэ хуульд заасны дагуу гаргасан хүсэлт, өргөдөл болон холбогдох бусад баримт бичгийн бүрдлийг;

3.1.13. “патентын олон улсын ангилал” гэж 1971 оны Патентын олон улсын ангиллын тухай Страсбургийн хэлэлцээрээр баталж, нэмэлт, өөрчлөлт оруулсан Патентын олон улсын ангиллыг;

3.1.14. “Патентын хамтын ажиллагааны гэрээ” гэж 1970 онд баталж, нэмэлт, өөрчлөлт оруулсан Патентын хамтын ажиллагааны гэрээ болон түүнийг дагаж гарсан дүрэм, журам, зааврыг;

3.1.15. “патент эзэмшигч” гэж патентаар хамгаалагдсан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварыг өмчлөх онцгой эрхийг хуульд заасан журмын дагуу олж авсан хувь хүн, хуулийн этгээдийг;

3.1.16. “шинжээч” гэж Оюуны өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан хүнийг;

3.1.17. “шинэ бүтээл” гэж байгалийн хуульд тулгуурлан сэдэж, үндэслэлийг нь тодорхойлсон бүтээгдэхүүн, үйлдвэрлэх арга, ажиллагаанд хамаарах техникийн шийдлийг.

11.1. Шинэ бүтээл, ашигтай загвар зохион бүтээгч, эсхүл түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээд патент авах эрхтэй байна.

15.2. Мэдүүлэг гаргагч патентын мэдүүлэг гаргахдаа оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлж болно.